



# ДОРНОГОВЬ ТҮНШЛЭЛ ХӨГЖИЛ 2024

Зорилтот жилийн тайлан



## “ТОГТВОРТОЙ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖИЛД ТҮҮЧЭЭЛНЭ”...



Дорнын шаргал говь нутгийнхаа ажилсаг, хөдөлмөрч түмэн олныхоо амар мэндийг айлтган мэндчилье.

Бид 2024 онд аймаг, орон нутгаа хөгжүүлэх зорилго бүхий Дорноговь аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөө амжилттай хэрэгжүүллээ.

Дорноговь аймаг 2024 онд аж үйлдвэрийн салбарт 513,3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 837 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 24,7 хувиар өсөн нэмэгдсэн байна. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2023 онд 824,9 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 169,2 сая төгрөгөөр өсөн нэмэгдэж, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 20,9 хувиар өссөн байна.

Хөдөлмөрч түмнийхээ хамтын хичээл зүтгэлээр өнгөрсөн 4 жилийн хугацаанд иргэдэд нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэх, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг нэмэгдүүлэх, эдийн засгийн ухаалаг бодлогыг хэрэгжүүлэхэд тодорхой ахиц дэвшлүүд гарсан. Тухайлбал боловсролын салбарт нийт 19,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэг, сургуулийн барилга байгууламжийн чанар, хүртээмжийг 100 хувьд хүргэсэн. Эрүүл мэндийн салбарт парк шинэчлэлт хийж, 4.3 тэрбум төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж шинээр нийлүүлснээр 11 нэр төрлийн эрүүл мэндийн үзлэг оношилгоо, 22 төрлийн лабораторийн шинжилгээг нэвтрүүлж, иргэд зарим төрлийн өндөр төлбөртэй эрүүл мэндийн үйлчилгээг орон нутагтаа авах боломж бүрдээд байна.

Бид 2025 оны зорилтоо “Аялал жуулчлалыг дэмжих жил” болгон зарлаж, орон нутгийн онцлог, шашин, түүхийн дурсгалт газруудад түшиглэн гадаад, дотоодын жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг өргөжүүлэн иргэдийнхээ хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэж байна. Түүнчлэн төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, төрийн үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг нэмэгдүүлж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх нэн тэргүүний зорилт оршиж байна.

Төрийн нуруу түвшин, түмний сэтгэл амгалан байх болтугай.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА ОЧИРПҮРЭВИЙН **БАТЖАРГАЛ**



## ЧАНАРТАЙ АМЬДРАЛ ЖАРГАЛТАЙ ИРГЭН

- ЭРҮҮЛ МЭНД
- БОЛОВСРОЛ
- ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ
- НИЙГМИЙН БҮЛЭГ
- СОЁЛ
- НИЙТИЙН БИЕЙН ТАМИР БА СПОРТ



## ЭХ БАЙГАЛЬ ЭЗЛТЭЙ ОРЧИН

- НОГООН ХӨГЖИЛ
- АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ МЕНЕЖМЕНТ
- БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ - УС АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ
- ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ - БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТ
- ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГ



## ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- АЖ ҮЙЛДВЭРИЙН ПАРК
- УУЛ УУРХАЙ
- ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЭ БҮТЭЦ
- БООМТ, ТЭЭВЭР ЛОГИСТИК
- ДЭД БҮТЭЦ
- АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ
- ХХАА, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЗ
- САНХҮҮ, ТӨСӨВ



## ӨРСӨЛДӨХ ЧАДВАР ӨГӨӨЖТЭЙ ОРОН НУТАГ

- "НЭЭЛТЭЙ ДОРНОГОВЬ АЙМАГ" ХӨТӨЛБӨР
- "ТҮНШЛЭЛ-ХӨГЖИЛ" БИЗНЕС ХӨТӨЛБӨР
- "ОРОН НУТГИЙН ӨГӨӨЖ" ХӨТӨЛБӨР
- САЙНШАНД-"GARDEN CITY", ЗАМЫН-ҮҮД-"SMART CITY"
- "АЯТАЙ ТУХТАЙ, АЮУЛГҮЙ ОРОН НУТАГ"
- 10000 АЙЛЫН ОРОН СУУЦ ХӨТӨЛБӨР



## ТҮМНИЙ ИТГЭЛ ТӨРИЙН МАНЛАЙЛАЛ

- ЦАХИМ-ДОРНОГОВЬ
- ТӨРИЙН АЛБАНЫ БОДЛОГО
- ИРГЭДИЙН ОРОЛЦОО
- ХҮНИЙ ЭРХ, ШУДАРГА ЁС
- АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ БАЙДАЛ
- ГАДААД ХАРИЛЦАА





## “ТҮНШЛЭЛ БА ХӨГЖИЛ” ЗОРИЛТОТ ЖИЛ

Дорноговь аймгийн Засаг даргын санаачилгаар 2024 оныг “Түншлэл ба Хөгжил” зорилтот жил болгон зарласан. “Түншлэл ба Хөгжил” зорилтот жилийн хүрээнд аймгийн бизнес эрхлэгчдэд урт хугацааны, хөнгөлөлттэй зээл олгох ажлыг ил тод, нээлттэй зохион байгуулсан.

**Төсөлд шалгарсан гарааны бизнес эрхлэгчдийг салбараар авч үзвэл:**

### ИРГЭН

- Нэхий боловсруулах үйлдвэр
- Хонины ноос боловсруулах эсгий үйлдвэрлэх
- Цахилгаан барааны засвар, үйлчилгээний нэгдсэн төв
- Хаягдал төмөр дахин боловсруулах
- Спортын сургалт, үйлчилгээ
- “Уран хуш” сийлбэр урлалын бүтээл
- Үндэсний сур харваа
- Мэдээллийн нэгдсэн цахим систем байгуулах
- Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- “Хөрш айл” аялал жуулчлал, үндэсний уламжлалт зан заншлыг бага, залуу үеийнхэнд таниулах үйл ажиллагаа
- Явуулын технологийн сургалтын үйл ажиллагаа
- “Баялаг тоорой” эрчимжсэн гахайны аж ахуй эрхлэх



Иргэд, аж ахуйн нэгжээс нийт 69 төслийн хүсэлт, мэдээлэл хүлээн авч хоёр дахь шатны сонгон шалгаруулалтын үр дүнд 8 аж ахуйн нэгж, 18 иргэнд орон нутгийн төсвөөс 1 тэрбум 951 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, орон нутагтаа тогтвортой үйл ажиллагаа эрхлэх боломжийг нэмэгдүүллээ.



- “Давхар амт” мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Үрлэн борц үйлдвэрлэл
- Эмчилгээний хоол, эрүүл хооллолт
- Өөртөө үйлчлэх угаалга
- Гэрийн модон тавилга үйлдвэрлэл
- “Babe barber shop” хүүхдийн үс засалтын төрөлжсөн төв

### АЖ АХУЙН НЭГЖ

- Ингэний сүүний үйлдвэрлэл
- Гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ
- Аарц, тараг, сүүний орц бүхий гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Малын тэжээлийн үйлдвэрлэл
- Эмчилгээний гоо сайхан
- “Эко говь” хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр
- Эрчимжсэн аж ахуй, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Мал эмнэлгийн суурин болон явуулын үйлчилгээ





## БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ

Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг "Бүсчилсэн Хөгжлийг Дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хорооноос 21 аймгийн 6 бүсчлэлд бодлого хэрэгжүүлэгчдийн нэгдсэн чуулганыг шат дараатайгаар зохион байгуулж, Дорноговь аймгийн төлөөлүүд оролцлоо.

Чуулганаар аймаг, орон нутгийн хөгжлийн зорилтыг төрөөс баримтлах бүсчилсэн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан хэрэгжүүлэхэд чиглэсэн нэгдсэн төлөвлөлтүүдийг танилцуулж хэлэлцлээ.

Дорноговь аймаг Засгийн газраас баримталж буй "Бүс нутгийн хөгжлийн бодлого"-той уялдуулан төв суурин газрын хүн амын төвлөрлийг сааруулж, орон нутагт ажиллаж, амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилт дэвшүүлэн 2023 онд "Нээлттэй Дорноговь" хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж, хотоос орон нутаг руу шилжин суурьшихаар ирж буй иргэд, аж ахуйн нэгжийг дэмжин хамтран ажиллаж байна.

"Нээлттэй Дорноговь" хөтөлбөрийн хүрээнд 2024 оны байдлаар 1715 ажлын байрыг шинээр бий болгож, 1635 иргэн байнгын болон түр ажлын байранд зуучлагдаж, орон нутагт ая тухтай амьдрах боломж бүрдсэн.



Үүний зэрэгцээ бүс нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор орон нутагт анх удаа “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг 2023 оноос батлан хэрэгжүүлж, 2024 онд 30 өрхийг түрээслээд өмчлөх буюу төлбөрийн уян хатан нөхцөлөөр шинэ орон сууцанд хамруулсан. Түүнчлэн шинээр инженерийн дулааны шугам сүлжээнд гэр хорооллын 573 өрхийн, 2800 гаруй иргэн хамрагдаж, орон нутагтаа тав, тухтай орчинд амьдрах боломжийг бүрдүүллээ.

Цаашид 14 суманд “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг шат дараатайгаар үргэлжлүүлэн хэрэгжүүлж, ялангуяа алслагдсан сумдад дулааны инженерийн шугам сүлжээг нэвтрүүлэх бодлогыг баримтлан ажиллана.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн Дорноговь аймаг 2022 онд цахим аймаг болох зорилт дэвшүүлэн Сайншанд суманд “ХурДан” төвийг орон нутгийн төсвийн 121,0 сая төгрөгийн санхүүжилтээр байгуулж, орон нутгийн хэмжээнд анх удаа цахим шинэчлэлтийг нэвтрүүлсэн тэргүүлэх аймаг болсон. “ХурДан” төвийн үйл ажиллагааг эхлүүлснээр төрийн цахим үйлчилгээ авах иргэдийн тоо сүүлийн 2 жилийн



хугацаанд 41,415 болон өргөжиж, ард иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдсэн.

Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас “Цахим аймаг” бодлогын хүрээнд цахим шилжилтийг үндэсний хэмжээнд эрчимжүүлэх, төрийн цахим үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр “Цахимд хэвшье” өдөрлөгийг Дорноговь аймагт амжилттай зохион байгууллаа.

Алслагдсан сумдад цахим үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор 2024 онд “ХурДан” төвийн салбар цэгийг 7 суманд байгуулж, иргэдэд төрийн үйлчилгээг илүү ойртуулж хүнд суртал, чирэгдэл багатай болгохоор зорилт дэвшүүлэн ажиллаж байна.



## ЗУДЫН ЭРСДЭЛД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Дорноговь аймагт 2023-2024 онд шилжих өвөл, хаврын улиралд нийт нутаг дэвсгэрийн 75 хувь болох Иххэт, Дэлгэрэх, Алтанширээ, Айраг, Даланжаргалан, Хөвсгөл, Эрдэнэ, Сайхандулаан, Мандах, Хатанбулаг, Сайншанд, Улаанбадрах, Замын-Үүд сумдад өвөлжилт хүндэрч байгаль, цаг уурын давагдашгүй хүнд нөхцөлтэй тулгарсан.

Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан аймгийн Онцгой комиссын шийдвэрээр 24 цагаар үүрэг гүйцэтгэх “Шуурхай штаб”-ыг байгуулан “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлэн байгаль, цаг уурын нөхцөл хүндэрсэн сумдын чиглэлд зам, гарц гаргах, малчдад түлээ түлш, хүнс, өвс тэжээл, техник хэрэгслээр дэмжлэг үзүүлэх ажлуудыг шат дараатай эрчимтэй зохион байгуулсан.

Зудын хүндрэлийг даван туулахад төрийн тусгай чиг үүргийн байгууллагын 102 албан хаагч, төрийн захиргаа болон төрийн үйлчилгээний 865 албан хаагч өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт үүрэг гүйцэтгэн 23,917 малчин өрхөд техник хэрэгсэл, өвс, тэжээл, нүүрс түлээ, хүнсний болон эмийн багц зэрэг шаардлагатай бүхий л тусламж, дэмжлэгийг үзүүлэн төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдээс нийт 7,0 тэрбум төгрөгийн хандив, тусламж төвлөрөн зарцуулагдсан.

Зудад өртсөн малын сэг зэм устгалын ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, 411 төрийн албан хаагч, 208 техник хэрэгсэлтэй ажиллаж, 119 устгалын цэгт 571,985



малын сэг зэмийг устган 148 хашаа хороо, 44 өтөг бууц, 43 уст цэг, 29,120 мкв бэлчээр нийт 175301 мкв талбайг халдваргүйжүүлсэн байна.

Үндэсний статистикийн хорооноос улсын хэмжээнд өрнүүлсэн малын зүй бус хорогдлыг тогтоох түүвэрчилсэн судалгаагаар Дорноговь аймгийн 14 сумын 3750 малчин өрхийн 547,463 толгой мал хорогдож, 428 малчин өрх нийт малынхаа 70 буюу түүнээс дээш хувийг, 41 малчин өрх 100 хувь буюу амьжиргааны эх үүсвэрээ бүрэн алдсан тухай дүгнэлт гарсан.

Дээрх судалгаанд үндэслэн зудын эрсдэлд өртсөн малчин өрхүүдийн амьжиргааг дэмжих төсөл, арга хэмжээний журмыг аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн захирамжаар баталсан.



Малчдын амьжиргааг дэмжих төсөл, арга хэмжээ нь 2024-2028 онд хэрэгжих төдийгүй журмын шаардлага хангасан малчин өрх тус бүрд 6,0 сая төгрөгийн санхүүжилтээр хээлтэгч бог мал худалдан авч малжуулахаар журамд тусгагдсан байна.

Хувийн хэвшил болох “Бадрах энерги” ХХК нь малчдын амьжиргааг дэмжих зорилгоор 300 сая төгрөгийг хандивлаж, тухайн дэмжлэгт багтаан Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Иххэт, Дэлгэрэх, Сайншанд зэрэг 6 сумын журмын шаардлага хангасан нийт 50 малчин өрхөд 1859 хээлтэгч бог мал олгон шийдвэрлэлээ.



ШИНЭ  
ХОРШОО  
ХӨДӨЛГӨӨН

“Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний хүрээнд Дорноговь аймагт 185 хоршоо шинээр байгуулагдан, 1768 малчин хоршоонд бүртгүүлж, 2024 оны 4 улирлын байдлаар хоршооны гишүүн болох 404 малчин 15,1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг авч үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна.





## ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРСОН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

### “ГОВИЙН БҮСИЙН АХМАД НАСТНЫ ТӨРӨЛЖСӨН АСРАМЖИЙН ГАЗАР” ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРЛОО

Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан орон нутгийн хэмжээнд анх удаа “Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газар” барих ажлыг Улсын төсвийн 2,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар бүтээн байгуулж, орон нутгийн төсвийн 108,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар орчин үеийн хэрэгцээт тоног төхөөрөмжөөр ханган асрамж, халамжийн үйлчилгээ шаардлагатай ахмад настнуудыг эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах боломжийг бүрдүүлсэн.



## ЗАМЫН-ҮҮД БООМТЫН АЧАА ТЭЭВРИЙН ЦОГЦОЛБОР

Замын-Үүд боомтын ачаа тээврийн цогцолборт улсын төсвийн 5,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Түргэн муудах бүтээгдэхүүний үзлэгийн байр” “Төмөр бетон суурьтай боомтын хяналтын бүсийн хашаа болон хаалганы барилга угсралт”, “Шатамхай бодисын агуулах, Анхны тусламжийн байр”, “Химийн бодисын агуулах”, Боомт, ачаа тээврийн цогцолборын ариутгал халдваргүйжүүлэлтийн барилга болон гадна цахилгаан холбооны байгууламж тус тус ашиглалтад орлоо.





## ЭМГЭГ СУДЛАЛЫН ТӨВ



Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн Эмгэг судлалын төвийг орон нутгийн хөгжлийн сангийн 299,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулаа.

## СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ



Замын-Үүд, Хатанбулаг сумдын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийг орон нутгийн төсвийн 2,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулаа.

## НӨӨЦИЙН АГУУЛАХ



Улаанбадрах, Сайншанд сумд орон нутгийн хөгжлийн сангийн 670,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Өвс тэжээлийн агуулах"-тай боллоо.

## ОРОН СУУЦ



Хатанбулаг суманд 8 айлын орон сууц барих ажлыг орон нутгийн төсвийн 1,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулаа.

## АВТО ЗОГСООЛ, ЯВГАН ХҮНИЙ ЗАМ, АВТО ЗАМ

Дорноговь аймгийн хэмжээнд 2024 онд улс болон орон нутгийн төсвийн 14,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 8,65 км авто зам, 9 байршилд 316

автомашины зогсоол, 207м дугуйн болон явган хүний замыг шинээр нэмэгдүүлж, ард иргэдийг ая, тухтай амьдрах орчныг бүрдүүллээ.




### ДАРААХ БАЙРШЛУУДАД:

- ЗАМЫН-ҮҮД СУМАНД ТӨВИЙН АВТО ЗАМ
- САЙНШАНД СУМЫН 1, 6, 7 ДУГААР БАГ
- САЙНШАНД СУМЫН 2-Р БАГИЙН ДЭНЖ ГУДАМЖ 11, 12-Р ХЭСЭГ
- ЗУУНБАЯН БАГТ 1,6 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ
- ЗАМЫН-ҮҮД СУМЫН 5 БАЙРШИЛ
- САЙНШАНД СУМЫН НОЁН ХУТАГТЫН-1 ГУДАМЖНЫ 30, 31-Р БАЙР
- САЙНШАНД СУМЫН 7-Р БАГИЙН ГАН ЗАМЧИД-1 ДҮГЭЭР ГУДАМЖ 150-Р БАЙР
- САЙНШАНД СУМЫН 2-Р БАГИЙН “ЭРХЧӨЛӨӨ-1” ГУДАМЖНЫ 100, 102-Р БАЙР
- САЙНШАНД СУМЫН ЗАЛУУЧУУД-3 ГУДАМЖНЫ 36-Р БАЙРНЫ ЗҮҮН ТАЛД 21, ЗАЛУУЧУУД-1 ГУДАМЖНЫ 103 БАЙР



## ЦАХИЛГААН ХАНГАМЖ

Дорноговь аймгийн хэмжээнд 2024 онд нийт улс болон орон нутгийн төсвийн 1,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 10,5 км 0,4 кВ-ын ЦДАШ-г шинээр барьж, 475 айл өрхийг цахилгаан эрчим хүчинд холбогдох боломжийг бүрдүүллээ.



## ЦАМХАГТ ГЭРЭЛ

Аймгийн хэмжээнд улс болон орон нутгийн төсвийн 2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 7км, 173 ширхэг гэрэлтүүлэг, 29 цамхагт гэрэл суурилуулан иргэдийн таатай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүллээ.



### ДАРААХ БАЙРШЛУУДАД:

- САЙНШАНД СУМАНД ХҮҮХДИЙН ПАРК РУУ ЗОРЧИХ АВТО ЗАМЫН ДАГУУ
- САЙНШАНД СУМЫН 1, 6, 7 ДУГААР БАГ
- САЙНШАНД 7-Р БАГ
- САЙНШАНД СУМЫН ЕБ-ЫН 3-Р СУРГУУЛИЙН УРД АВТО ЗАМ
- САЙНШАНД СУМЫН 4,7-Р БАГ
- ЗАМЫН-ҮҮД ЧИГЛЭЛД ТӨМӨР ЗАМЫН ГАРАМ

## ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ШИНЭЧЛЭЛТ

Дорноговь аймаг 2024 онд улс болон орон нутгийн төсвийн 11,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 31,8 км инженерийн шугам сүлжээг шинэчлэн засварлаж,

675 өрх, 15 байгууллагыг төвлөрсөн шугамд холбон орон нутагтаа ая тухтай ажиллаж, амьдрах орчныг бүрдүүллээ.



### ДАРААХ БАЙРШЛУУДАД:

- САЙНШАНД СУМЫН 1-Р БАГТ ДАНЗАНВААНЧИГИЙН 9, 10 ГУДАМЖ
- ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ЦОМОГ БАГТ БАРИГДАХ ОРОН СУУЦНЫ БАРИЛГА
- УЛААНБАДРАХ СУМАНД НЭГДСЭН ДУЛААН, ЦЭВЭР УСНЫ ШУГАМ
- МАНДАХ СУМАНД ТӨВЛӨРСӨН УС, ДУЛААН, БОХИРЫН ШУГАМ



## 2024 ОНЫ СПОРТЫН АМЖИЛТУУД

Дорноговь аймгийн Айраг сумын харьяат Үндэсний бөхийн аймгийн арслан Баасандоржийн Бадрал Польш улсад зохион байгуулагдсан сонирхогчдын Сумо бөхийн “Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн”-ий -115кг-ийн жинд барилдаж аваргын Алтан медалийн болзол хангаснаар Дэлхийн гурван удаагийн аварга боллоо.

•Дорноговь аймгийн Сайншанд сумын иргэн Суватилийн Жиеэнхаан Арабын Нэгдсэн Эмират улсын Абу Даби хотноо зохион байгуулагдсан Жюү Жицү мастерсын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний М3 ангиллын Ягаан бүсний -94кг жингийн аварга, Япон улсын Нагояа хотноо зохион байгуулагдсан Азийн спорт Жюү жицүгийн холбооны мастерсын “Дэлхийн аварга” болсноор Монголын Жюү жицүгийн “Golden Garuda-2024” оны мастерс ангиллын шилдэг тамирчнаар шалгарсан байна.



•Оюуны спортын төрлөөр Дорноговь аймгийн Сайншанд сумын ЕБ-ын 1, 2, 5, 6 дугаар сургуулийн суралцагч О.Цэлмүүн, Э.Энхсанаа, А.Ачит, О.Оюумаа нар Энэтхэг Улсын Дели хотод зохион байгуулагдсан “Дэлхийн аварга шалгаруулах цээж тоолол, соробан сампингийн тэмцээн”-д Монгол Улсаа төлөөлөн оролцож “Дэлхийн аварга” боллоо.





•Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн суралцагч Уранбилэгийн Ухаанбилэг Тайланд улсын Бангкок хотод зохион байгуулагдсан сурагчдын Ази тивийн аварга шалгаруулах шатрын тэмцээнд тэргүүн байр эзэлж, “Азийн аварга” боллоо.

•Дорноговь аймгийн Сайхандулаан сумын харьяат, “Аваргууд академи”, “Номт-Даншиг” ХХК-ийн тамирчин, бөхийн чөлөөт барилдааны ОУХМастер Чинболдын Отгонтуяа Йордан улсын Амман хотноо

зохион байгуулагдсан Чөлөөт бөхийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээний 53кг-ийн жинд түрүүлж “Азийн аварга” боллоо. Мөн Албани Улсын нийслэл Тирана хотод чөлөөт бөхийн “U23” насны дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Чинболдын Отгонтуяа хүрэл медаль хүртэв.

•Улсын аварга шалгаруулах Хөнгөн атлетик, Гандбол, Сагсан бөмбөг, Пауэрлифтинг зэрэг 18 төрлийн тэмцээнд Дорноговь аймгийн тамирчид оролцож, 32 “Алтан медаль” хүртэн медалийн чанараа ахиуллаа.



## ДОРНОГОВЬ АЙМАГ ФУТЗАЛЫН 21 АЙМГИЙН АВАРГА ШАРГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ “ҮНДЭСНИЙ ЦОМ”-ЫН ЭЗЭН БОЛЛОО



Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Үндэсний цом” болон футзалын 21 аймгийн аварга шалгаруулах тэмцээнд Дорноговь аймгийн Хөлбөмбөгийн шигшээ багийн тамирчид тэргүүн байрт шалгарч “Үндэсний цом”-ын эзэд боллоо.

## ДОРНОГОВЬ АЙМГИЙН БАГ “МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЦОМ” -ЫН ЭЗЭД БОЛЛОО



Үндэсний шагайн харвааны Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит “Шилжин явах цом”-ын төлөөх хоёр дахь удаагийн тэмцээнд МУ-ын Үлэмж дархан мэргэн, спортын мастер Б.Баттулга ахлагчтай

Дорноговь аймгийн “Номт даншиг хэттрик групп”-ийн баг шалгарч “Шилжин явах цомын эзэн” боллоо.



## МОНГОЛ УЛСЫН 2024 “ОНЫ ОНЦЛОХ ХҮҮХЭД”-ЭЭР ДОРНОГОВЬ АЙМГААС ХОЁР ХҮҮХЭД ТОДОРЛОО

Монгол Улсын “ОНЫ ОНЦЛОХ ХҮҮХЭД” шалгаруулах үйл ажиллагаа 2024 онд 32 дэх жилдээ үндэсний хэмжээнд зохион байгуулагдлаа. Үүнд 1678 хүүхэд өрсөлдөж, онцгой амжилт гарган эх орноо сурталчлан таниулсан урлаг, спорт, сурлага хөдөлмөрийн амжилтаараа үе тэнгийнхнээ манлайлсан 74 хүүхэд шалгарсан. Эдгээрт Дорноговь аймгаас 2 хүүхэд багтсан амжилтыг үзүүллээ.

Тодруулбал:

- Биеийн тамир, спортын төрөлд Сайншанд сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургууль 86 ангийн суралцагч М.Өэлүн
- Арабын Нэгдсэн Эмират улсын Абу Даби хотноо зохион байгуулагдсан Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд улбар шар бүсний 2-р байр,
- Улсын аварга шалгаруулах “Жюү Жицү”-ийн тэмцээнд өсвөрийн аварга
- Техник сэтгэлгээ, шинэ санал санаачилга, бүтээлч байдал төрөлд Сайншанд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 96 ангийн суралцагч Б.Пүрэвсүрэн
- “SCIENCE FAIR 2024” Шинжлэх ухааны бүтээлийн уралдаанд “Хаягдлаас хэрэглээ рүү” бүтээлээр тэргүүн байр

- Монгол Улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан доктор О.Доржрэнчингийн нэрэмжит Химийн багийн олимпиадад 2-р байр
- Боловсролын тэргүүний ажилтан Б.Түвшинтөгсийн нэрэмжит Газар зүйн Улсын олимпиадад тэргүүн байр эзэлсэн амжилтуудаараа шилдгээр шалгарлаа.




## МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ЭМЧ ТОДОРЛОО



- Монгол Улсын Гавьяат хуульч Дашнямын Цогтсайхан



- Монгол Улсын хүний Гавьяат эмч Халтарын Эрдэнэбулган





## МОНГОЛ УЛСЫН ХОШОЙ АВАРГА МАЛЧИН ТОДОРЛОО

1. Хөвсгөл сумын Элст багийн малчин Галсаншадавын Ууганбаяр



## МОНГОЛ УЛСЫН АВАРГА МАЛЧИН ТОДОРЛОО

- |                      |                            |                          |
|----------------------|----------------------------|--------------------------|
| 1. Айраг сум         | Нард багийн малчин         | Гантөмөрийн Оюунбаатар   |
| 2. Даланжаргалан сум | Бичигт багийн малчин       | Бямбын Эрдэнэдалай       |
| 3. Иххэт сум         | Баян багийн малчин         | Лепийн Батсайхан         |
| 4. Мандах сум        | Өехий багийн малчин        | Энхтайваны Тавхай        |
| 5. Өргөн сум         | Сүмийн булаг багийн малчин | Цэдэвийн Батчулуун       |
| 6. Сайхандулаан сум  | Жаргалант багийн малчин    | Хорлоогийн Батсайхан     |
| 7. Улаанбадрах сум   | Баянбогд багийн малчин     | Найдансүрэнгийн Амарбаяр |
| 8. Хөвсгөл сум       | Элст багийн малчин         | Аюурын Сүхбаяр           |
| 9. Эрдэнэ сум        | Дөрвөлж багийн малчин      | Доржийн Ганзориг         |



## АЛТАН ТӨЛИЙН ЭЗЭД ТОДОРЛОО

- |                      |             |                          |
|----------------------|-------------|--------------------------|
| 1. Айраг сум         | Алтан хурга | Дэлгэрсуурийн Баттүвшин  |
| 2. Алтанширээ сум    | Алтан ботго | Отгон-Амжилтын Эрдэнэбат |
| 3. Даланжаргалан сум | Алтан хурга | Дэлгэрсайханы Энхжаргал  |
| 4. Дэлгэрэх сум      | Алтан хурга | Мажигийн Амаржаргал      |
| 5. Өргөн сум         | Алтан ботго | Цэдэвийн Батханд         |
| 6. Өргөн сум         | Алтан хурга | Халзанхүүгийн Бат-Идэр   |
| 7. Улаанбадрах сум   | Алтан унага | Ангирагийн Мөнхбаяр      |
| 8. Улаанбадрах сум   | Алтан тугал | Найдангийн Мөнхсуурь     |
| 9. Сайхандулаан сум  | Алтан ботго | Цэрэннадмидын Ганцоож    |
| 10. Хөвсгөл сум      | Алтан ботго | Болдбаатарын Баярбат     |
| 11. Хатанбулаг сум   | Алтан унага | Адъяагийн Отгонбаатар    |
| 12. Мандах сум       | Алтан ботго | Донхоонгийн Банзрагч     |



## АЙМГИЙН АЛДАРТ УЯАЧИД ТОДОРЛОО

1.	Айраг сум	Ням-Осорын	Бүрэнбат
2.	Даланжаргалан сум	Чимэд-Очирын	Лхагвагэрэл
3.		Бямбын	Эрдэнэдалай
4.		Өлзийсайханы	Мөнхбаяр
5.	Дэлгэрэх сум	Лхагвагийн	Очирпүрэв
6.		Намсрайн	Чулуунсүх
7.		Гантулгын	Дамба
8.		Бэгзсүрэнгийн	Адъяасүрэн
9.		Буянравжихын	Болдсайхан
10.	Иххэт сум	Алтангэрэлийн	Түвшинбаатар
11.		Гансайханы	Намуунзул
12.	Мандах сум	Гонгорын	Батмөнх
13.		Гансүхийн	Тэгшжаргал
14.		Пүрэвжамцын	Батхүү
15.		Балданжамцын	Амгаланбаяр
16.	Сайхандулаан сум	Насантогтохын	Эрдэнэтөгс
17.		Сүхбаатарын	Хүрэлсүх
18.		Лувсанжамбын	Улаанхүү
19.	Сайншанд сум	Доржсүрэнгийн	Дашням
20.	Улаанбадрах сум	Адъяагийн	Баттогтох
21.		Батчулууны	Энхбат
22.		Эрдэнэбатын	Оргилболд
23.	Өргөн сум	Гончигийн	Бат
24.		Ууганбаатарын	Билгээ
25.		Лувсангийн	Ухна
26.	Хөвсгөл сум	Батчулууны	Мөнх-Эрдэнэ
27.	Хатанбулаг сум	Данзанямын	Баттөмөр
28.		Ганболдын	Энхтүвшин
29.	Замын-Үүд сум	Жигрийгийн	Бямбацогт
30.	Эрдэнэ сум	Энэбишийн	Оюунбат



## АЙМГИЙН ХОШОЙ АВАРГА, АЙМГИЙН АВАРГА МАЛЧИН, АВАРГА ТЭМЭЭЧИН, СААЛЬЧИН ТОДОРЛОО

Мал сүргээ өсгөн үржүүлж, ашиг шимийг нь нэмэгдүүлэн, малч ухаан, ажиллах арга туршлагаараа бусдыгаа манлайлан хөдөлмөрлөж байгаа “Аймгийн хошой аварга малчин” 10 малчин, “Аймгийн аварга малчин” 46 малчин, “Аймгийн аварга тэмээчин” 3 малчин, “Аймгийн аварга саальчин” 1 малчин тус тус тодорлоо.



## АЙМГИЙН ХОШОЙ АВАРГА МАЛЧИД ТОДОРЛОО

1. Айраг сумын Сайн-Ус багийн малчин Отгоны **Оюунжаргал**
2. Айраг сумын Нүдэн багийн малчин Насанжаргалын **Туул**
3. Сайншанд сумын Ялалт багийн малчин Дуламын **Данзанваанчиг**
4. Сайншанд сумын Ялалт багийн малчин Болоожийн **Оргой**
5. Хөвсгөл сумын Чулуут багийн малчин Тамаарын **Баярбилэг**
6. Хөвсгөл сумын Элст багийн малчин Гүнгэрэгийн **Мөнхбат**
7. Хөвсгөл сумын Элст багийн малчин Донровжамцын **Энхболд**
8. Хатанбулаг сумын Агаруут багийн малчин Сумъяагийн **Улсболд**
9. Хатанбулаг сумын Сулинхээр багийн малчин Батдоржын **Ундрах**
10. Эрдэнэ сумын Еншөөв багийн малчин Өвгөний **Батбаяр**

## АЙМГИЙН АВАРГА МАЛЧИД ТОДОРЛОО

1. Айраг сумын Нард багийн малчин Цогт-Очирын **Эрдэнэбаяр**
2. Айраг сумын Сайн-Ус багийн малчин Галбаатарын **Мөнхбат**
3. Айраг сумын Цагаандөрвөлж багийн малчин Баяржаргалын **Нямсүрэн**
4. Алтанширээ сумын Тойг багийн малчин Бямбадоржийн **Жамбал**
5. Алтанширээ сумын Зараа багийн малчин Цэдэвдоржийн **Мөнхбат**
6. Алтанширээ сумын Хаяа багийн малчин Ганхуягийн **Түмэнбаатар**
7. Даланжаргалан сумын Элдэв багийн малчин Дэлгэрсайхан **Энхтүвшин**
8. Даланжаргалан сумын Элдэв багийн малчин Охинбаатарын **Түмэнжаргал**





9. Даланжаргалан сумын Өнгөт багийн малчин Чимэд-Очирын Алтангэрэл
10. Даланжаргалан сумын Өнгөт багийн малчин Батхуягийн Даваажав
11. Даланжаргалан сумын Бичигт багийн малчин Арвайн Наранболд
12. Дэлгэрэх сумын Цагаан хад багийн малчин Пүрэвзавын Сод-Эрдэнэ
13. Дэлгэрэх сумын Аманшанд багийн малчин Монхорын Чинбат
14. Дэлгэрэх сумын Бумбат багийн малчин Гэндэнзавын Биндэръяа
15. Иххэт сумын Бүрдэнэ багийн малчин Төмөрийн Мөнхбат
16. Иххэт сумын Баян багийн малчин Дорждэрэмийн Өлзийхутаг
17. Иххэт сумын Баян багийн малчин Дугарын Эрдэнэхүү
18. Өргөн сумын Сүмийн булаг багийн малчин Жанчивдоржийн Баяржаргал
19. Өргөн сумын Сүмбэр багийн малчин Мягмарын Бат-Эрдэнэ
20. Өргөн сумын Баянмөнх багийн малчин Ухнын Очбаяр
21. Өргөн сумын Баянмөнх багийн малчин Чимэдийн Ууганбаяр
22. Сайншанд сумын Ялалт багийн малчин Цэндсүрэнгийн Хосбаяр
23. Сайншанд сумын Ганзам багийн малчин Гаатаны Гомпил
24. Сайншанд сумын Ганзам багийн малчин Дамдинсүрэнгийн Ган-Од
25. Сайхандулаан сумын Улааншороот багийн малчин Хүрэлбаатарын Мөнхбаатар
26. Сайхандулаан сумын Жаргалант багийн малчин Доржийн Отгонбаяр
27. Сайхандулаан сумын Цохио багийн малчин Лувсандондовын Бат-Эрдэнэ
28. Мандах сумын Алхантаг багийн малчин Жавзмаагийн Мөнхпүрэв
29. Мандах сумын Баянхошуу багийн малчин Ухнын Мягмаржав
30. Мандах сумын Өехий багийн малчин Ичинхоролын Болдбаатар
31. Мандах сумын Сэрвэнбаянхошуу багийн малчин Батжаргалын Борбилбаатар
32. Хөвсгөл сумын Жавхлант багийн малчин Баярмагнайн Ган-Эрдэнэ
33. Хөвсгөл сумын Чулуут багийн малчин Гантөмөрийн Үүрцайх
34. Хөвсгөл сумын Элст багийн малчин Рагчаагийн Алтанболд
35. Хатанбулаг сумын Халив багийн малчин Бандийн Одбаяр



36. Хатанбулаг сумын Эргэл багийн малчин Лувсанжамцын **Баттоого**
37. Хатанбулаг сумын Агаруут багийн малчин Намсрайн **Мөнх-Өлзий**
38. Улаанбадрах сумын Сангийн далай багийн малчин Бавуудоржийн **Батбаяр**
39. Улаанбадрах сумын Сангийн далай багийн малчин Цэгмэдийн **Энхтөр**
40. Улаанбадрах сумын Баянбогд багийн малчин Батболдын **Бат-Эрдэнэ**
41. Улаанбадрах сумын Аргалант багийн малчин Дамбадаржаагийн **Мөнхсуурь**
42. Эрдэнэ сумын Бүрдэнэ багийн малчин Цэрэндэндэвийн **Чинзориг**
43. Эрдэнэ сумын Бүрдэнэ багийн малчин Гомбын **Алтанхуяг**
44. Эрдэнэ сумын Еншөөв багийн малчин Даарийчулууны **Батдэлгэр**
45. Эрдэнэ сумын Дөрвөлж багийн малчин Ухнын **Болдбаатар**
46. Эрдэнэ сумын Дөрвөлж багийн малчин Балжиннямын **Цэндбаатар**

### “АЙМГИЙН АВАРГА ТЭМЭЭЧИН”-ЭЭР:

1. Сайхандулаан сумын Цохио багийн малчин Эрдэнэбилэгийн **Баярхүү**
2. Хатанбулаг сумын Сулинхээр багийн малчин Орловын **Наранбаяр**
3. Эрдэнэ сумын Цагаан хөтөл багийн малчин Баавгайн **Ариунболд**

### “АЙМГИЙН АВАРГА СААЛЬЧИН”-ААР:

1. Эрдэнэ сумын Бүрдэнэ багийн малчин Батсүхийн **Батгэрэл**





МОНГОЛ УЛСЫН  
САЙН ШАНД СУМЫН  
100 ЖИЛИЙН ОЙ  
ТОХИОЛОО

## СУМДЫН 100 ЖИЛИЙН ОЙ ТОХИОЛОО

Монгол Улсын хэмжээнд 2024 онд 17 аймгийн 102 сумын зуун жилийн тэгш ой тохиосон. Дорноговь аймгийн хэмжээнд 11 сумын 100 жилийн ой, Сайншанд сумын 63 жил, Замын-Үүд сумын 30 жилийн ойн баяр наадмыг тус тус тэмдэглэн өнгөрүүлсэн.



### САЙНШАНД СУМ

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөв хамтдаа-2” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих хугацаанд Сайншанд суманд Улс болон орон нутгийн төсвийн 21 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинэ барилга байгууламж, тохижилт засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн шинэчлэлт зэрэг нийт 264 төрлийн бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг үр дүнтэй зохион байгуулан иргэдийн тав тухтай амьдрах нөхцөл боломжийг бүрдүүллээ.

100 жилийн тэгш ой тохиосон сумдад сүүлийн 4 жилийн хугацаанд аймаг, орон нутгийн хөгжлийн бодлогоор хийгдсэн томоохон бүтээн байгуулалтын ажлуудийг онцлон тэмдэглэлээ.



### ЗАМЫН-ҮҮД СУМ

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөв хамтдаа-2” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих хугацаанд Замын-үүд суманд Улс болон орон нутгийн төсвийн 87,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Мандах наран-5” орон сууцны хорооллын гадна дулаан, цэвэр ус, бохир усны шугам сүлжээний ажил, “Хүүхэд хөгжлийн төв”-ийн барилга барих ажил, камерын хяналт, удирдлагын нэгдсэн систем байгуулах ажил, Иргэдийн хөгжлийн төвийн барилга барих ажил, 640 хүүхдийн сургуулийн барилгын ажил, ундны усны 3000 м3 багтаамжтай усан сан барих ажил зэрэг нийт 65 төрлийн томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг үр дүнтэй зохион байгуулж амжилттай хэрэгжүүлээ.





## АЙРАГ СУМ

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих хугацаанд Айраг суманд улс болон орон нутгийн төсвийн 3,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар ариутгах татуургын шугам, насос станцын барилга, тоног төхөөрөмж угсрах ажил, Дулааны станцын 3-р зуух шинэчлэл, Соёл, спортын төвийн барилга, сумын төвийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, хүүхдийн тоглоомын талбай, авто зогсоол, явган хүний зам байгуулах зэрэг нийт 14 төрлийн шинэчлэлт, бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



## АЛТАНШИРЭЭ СУМ

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих хугацаанд Алтанширээ суманд улс болон орон нутгийн төсвийн 6,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Тойг, Хаяа багийн төвийн барилгын өргөтгөл, нийтийн орон сууцыг гадна дулаан цэвэр усны шугамд холболт, сумын төвийн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн ажил, сумын төсөвт байгууллагуудыг төвлөрсөн халаалтад холбох зэрэг нийт 15 төрлийн бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг үр дүнтэй зохион байгуулан иргэдийн тав тухтай амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлээ.





МОНГОЛ УЛСЫН  
СОЁЛ, ХАМГААГАХ  
ЭРХЭМ АЖЛААСНЫ  
ЯРИХ



## ДАЛАНЖАРГАЛАН СУМ

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих хугацаанд Алтанширээ суманд улс болон орон нутгийн төсвийн 6,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 15 ортой Эрүүл мэндийн төвийн барилга, сумын төвийн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн ажил, “Их нарт” байгалийн нөөц газрын сургалт мэдээллийн төвийн барилга, ЕБС-ын хичээлийн байр, спорт заалны сантехник, цахилгааны засвар зэрэг нийт 21 төрлийн бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг үр дүнтэй зохион байгуулан иргэдийн тав тухтай амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэв.



## ДЭЛГЭРЭХ СУМ

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих хугацаанд Дэлгэрэх суманд улс болон орон нутгийн төсвийн 10 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар туулах чадвар сайтай суудлын автомашин, нийтийн биеийн тамирын талбай, сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламж, цаг уурын станцын барилга шинээр барих зэрэг нийт 19 төрлийн бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг үр дүнтэй зохион байгуулан иргэдийг тав тухтай амьдрах нөхцөл боломжоор хангав.





## ИХХЭТ СУМ

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөв хамтдаа-2” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих хугацаанд Иххэт суманд улс болон орон нутгийн төсвийн 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар туулах чадвар сайтай суудлын автомашин, Нийтийн эзэмшлийн орон сууцны дээвэр, гадна дулаалга, зоорийн болон гадна инженерийн шугам сүлжээний засвар, шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн угсралт, сумын төвийн цэвэр усны шугамыг шинэчлэх зэрэг нийт 17 төрлийн бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг үр дүнтэй зохион байгуулан иргэдийн тав тухтай амьдрах нөхцөл боломж бүрдэв.



## МАНДАХ СУМ

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөв хамтдаа-2” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих хугацаанд Мандах суманд улс болон орон нутгийн төсвийн 12,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар төвлөрсөн шугам сүлжээний зураг төсвийн ажил, 100 хүүхэд хүлээж авах чадвартай цэцэрлэгийн барилга, туулах чадвар сайтай суудлын автомашин худалдан авах зэрэг нийт 19 төрлийн бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг үр дүнтэй зохион байгуулан иргэдийн тав тухтай амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүллээ.





МОНГОЛ УЛСЫН  
АЖААХУЙ АХУЙ  
АЖААХУЙ АЖААХУЙ  
АЖААХУЙ АЖААХУЙ  
АЖААХУЙ АЖААХУЙ



## ӨРГӨН СУМ

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих хугацаанд Өргөн суманд улс болон орон нутгийн төсвийн 11,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай автозамаас Өргөн сум хүртэлх 18.25 км хатуу хучилттай авто зам, Спорт заалны барилга, сумын Ахмадын өргөөний барилга зэрэг нийт 14 төрлийн бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг үр дүнтэй зохион байгуулан иргэд тав тухтай амьдрах орчин нөхцөл бүрдэв.



## САЙХАНДУЛААН СУМ

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих хугацаанд Сайхандулаан суманд улс болон орон нутгийн төсвийн 3,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар туулах чадвар сайтай суудлын автомашин, сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламж, “Монгол соёл-Монгол хүмүүн” төсөл хөтөлбөр зэрэг нийт 12 төрлийн бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг үр дүнтэй зохион байгууллаа.





## ХАТАНБУЛАГ СУМ

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөв хамтдаа-2” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих хугацаанд Хатанбулаг суманд улс болон орон нутгийн төсвийн 18,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Спорт цогцолборын барилга, туулах чадвар сайтай суудлын автомашин, 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилга, сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламж зэрэг нийт 31 төрлийн бүтээн байгуулалтын зорилтот томоохон ажлууд хийгдлээ.



## ХӨВСГӨЛ СУМ

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөв хамтдаа-2” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих хугацаанд Хөвсгөл суманд улс болон орон нутгийн төсвийн 14,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар туулах чадвар сайтай суудлын автомашин, 200 хүний суудалтай Соёл, спортын төв, сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламжийн ажил, Эрүүл мэндийн төвийн лаборатори тоног төхөөрөмж худалдан авах зэрэг нийт 16 төрлийн бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг үр дүнтэй зохион байгуулан иргэд сумандаа сайхан амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлээ.





МОНГОЛ УЛСЫН  
АЖ АХуйн болон  
ХАВЧИЛГААНЫ  
ХАМГААГАХ  
ХАРИУЦЛАГААНЫ  
ТӨСӨӨР



## ЭРДЭНЭ СУМ

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих хугацаанд Эрдэнэ суманд улс болон орон нутгийн төсвийн 2,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламжийн ажил, 80 ортой Дотуур байр, сумын ЕБС-ийн хичээлийн байр, сумын ЭМТ-ийн өргөтгөлийн барилга, Хилийн 0129 дугаар ангийн орчин нөхцлийг сайжруулах, тоног төхөөрөмж худалдан авах зэрэг нийт 21 төрлийн бүтээн байгуулалтын томоохон ажлыг зохион байгуулж иргэд тав тухтай амьдрах нөхцөл боломжийг бүрдүүллээ.



## УЛААНБАДРАХ СУМ

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих хугацаанд Улаанбадрах суманд улс болон орон нутгийн төсвийн 4.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар туулах чадвар сайтай суудлын автомашин, төрийн албан хаагчийн 6 айлын орон сууцны барилга барих ажил, төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламжийн ажил, тохижилт, их засварын ажил зэрэг нийт 17 төрлийн бүтээн байгуулалтын ажил хийгдлээ.



## ДОРНОГОВЬ АЙМГИЙН УУГАН СУРГУУЛИЙН 100 ЖИЛИЙН ОЙ ТОХИОЛОО

Дорноговь аймгийн ууган Ерөнхий боловсролын сургууль болох Нэгдүгээр сургуулийн түүхт 100 жилийн ой 2024 онд тохиолоо. Сургуулийн ойг тохиолдуулан орон нутгийн төсвийн 1,9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр бүрэн засвар хийж суралцагчдын тав тухтай, таатай орчинд сурч боловсрох нөхцөлийг нэмэгдүүллээ.

Сургуулийн иж бүрэн засварын ажлын хүрээнд:

1. Урлаг болон спорт заал, гал тогоо
2. Гадна пасад болон дотор засал
3. Коридор, ариун цэврийн өрөө
4. Цахилгааны монтаж зэрэг үндсэн 4 хэсэгт мэргэжлийн баг ажиллаж, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Төрөлх сургуулийнхаа ойн баярыг тохиолдуулан үе үеийн төгсөгчид болон нутгийн түмэн олны зүгээс хандивын аяныг өрнүүлэн нийт 310 сая төгрөгийн дэмжлэгийг төвлөрүүлэн тохижилт шинэчлэлт, ойн үйл ажиллагаанд зарцуулжээ.





## ДОРНОГОВЬ АЙМАГ ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАНЫ 93 ЖИЛИЙН ОЙН БАЯР НААДАМ БОЛЛОО

Домог түүхийн өлгий  
Догшин Ноён Хутагтаараа овоглосон  
Дорнын шаргал говь

Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн хошой одонт  
Дорноговь аймаг байгуулагдсаны түүхт 93 жилийн  
ойн баяр наадмаа 2024 оны 07 дугаар сарын 27, 28-ны  
өдрүүдэд ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүллээ.

Баяр наадамд хүчит 128 бөх, зургаан насны 200  
гаруй шандаст хүлэг, 120 гаруй сурын мэргэн харваач,  
240 гаруй шагайн харваач оролцож цэц мэргэнээ  
сорьсон байна.



## ҮНДЭСНИЙ БӨХИЙН БАРИЛДААН

Үндэсний бөхийн барилдаанд 128 бөх зодоглосноос түрүү бөхөөр Айраг сумын харьяат “Хутагтын хүчтэн” дэвжээний бөх аймгийн начин С.Занданхүү түрүүлэн аймгийн арслан цол хүртэж, “Хутагтын хүчтэн” дэвжээний бөх аймгийн заан Б.Түвшинтулга үзүүрлэв.

### ХУРДАН МОРИНЫ УРАЛДААН

#### АЗАРГАНЫ УРАЛДААН

- 1.Б.Ганзоригийн зээрд Улаанбадрах сум
- 2.О.Батдоржийн хээр Дэлгэрэх сум
- 3.Б.Батсайханы хээр Алтанширээ сум
- 4.Аймгийн алдарт уяач Б.Өсөхбаярын сартай хээр Алтанширээ сум
- 5.Аймгийн алдарт уяач У.Отгонбилэгийн зээрд Сайхандулаан сум

#### ИХ НАСНЫ УРАЛДААН

1. Сумийн алдарт уяач Ө.Балчиндоржийн зээрд Иххэт сум
2. Аймгийн алдарт уяач О.Саруулбаярын хээр Сайншанд сум
3. Аймгийн алдарт уяач М.Жаргалсайханы хар Хатанбулаг сум
4. Аймгийн алдарт уяач Б.Мөнх-эрдэнийн хээр Хөвсгөл сум
5. Ч.Ганбаярын шарга Улаанбадрах сум

#### ХУРДАН СОЁОЛОН НАСНЫ УРАЛДААН

- 1.Аймгийн алдарт уяач Э.Оргилболдын зээрд халзан Улаанбадрах сум
- 2.Аймгийн алдарт уяач Ц.Ганбатын халиун Сайншанд сум
- 3.О.Одбаярын сартай хар Сайншанд сум
- 4.Б.Мөнхтүвшингийн зээрд халзан Алтанширээ сум
- 5.Аймгийн алдарт уяач Д.Баттогтохын халтар Улаанбадрах сум





### ХЯЗААЛАН НАСНЫ УРАЛДААН

1. Б.Наранбаярын хонгор халзан Улаанбадрах сум
2. Ц.Баатарцогтын хээр Хөвсгөл сум
3. Ө.Баярбилэгийн бор Өргөн сум
4. Э.Шинэбаярын зээрд халзан Алтанширээ сум
5. О.Батдоржийн зээрд Дэлгэрэх сум

### ШҮҮДЛЭН НАСНЫ УРАЛДААН

1. Т.Гантулгийн хээр Алтанширээ сум
2. Аймгийн алдарт уяач Б.Эрдэнэболдын хүрэн Хөвсгөл сум
3. Сумын алдарт уяач А.Ган-Одын хүрэн Хатанбулаг сум
4. Б.Энхбатын хонгор Иххэт сум
5. Х.Эрдэнэбулганы Хонгор Дэлгэрэх сум

### ДААГАНЫ УРАЛДААН

1. Аймгийн алдарт уяач О.Саруулбаярын зээрд Сайншанд сум
2. Б.Баярнямын хул Сайхандулаан сум
3. Д.Төрбилэгийн хүрэн Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сум
4. Аймгийн алдарт уяач А.Баттогтох хээр Улаанбадрах сум
5. Аймгийн алдарт уяач Б.Өсөхбаярын хүрэн Алтанширээ сум



## ҮНДЭСНИЙ СУР ХАРВАА

Баяр наадмын Үндэсний сурын харваанд Монгол улсын Даян мэргэн Д.Түвшин, Монгол улсын онч харваач Б.Наадам, аймгийн Мэргэн, Спортын мастер Л.Галсанцэрэн, А.Энхтайван, Э.Эрдэнэгэрэл, Ч.Чинзориг, Т.Дуламсүрэн, Д.Энхсайхан тэргүүтэй Дорноговь аймаг болон Улаанбаатар хот, Говь-Сүмбэр, Сүхбаатар, Өмнөговь, Дундговь, Дорнод зэрэг аймгуудийн 120 гаруй харваач оролцож, цэц мэргэнээ сорилоо.

### НАСАНД ХҮРЭГЧДИЙН ЭРЭГТЭЙ ТӨРӨЛД:

#### • ТЭРГҮҮН БАЙР

Говь-Алтай аймгийн Бигэр сумын уугуул, Дорноговь аймгийн Сайншанд сумын харьяат “Өнөд цэнгэлийн манлай” харваачдын холбооны харваач, спортын мастер Гомбодоржийн Хатанбаатар /37 оноо/

#### • ДЭД БАЙР

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын уугуул, Улаанбаатар хотын Багануур дүүргийн харьяат Үндэсний сурын холбооны харваач, аймгийн онч харваач Наранцэцэгийн Цолмон /36 оноо/

#### • ГУТГААР БАЙР

Ховд аймгийн Мөнххайрхан сумын уугуул, Модун клубын харваач, спортын мастер Жаргалдалайн Энх- Амгалан /35 оноо/

#### • ДӨТГӨӨР БАЙР

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын уугуул, Дорноговь аймгийн Үндэсний сурын холбооны харваач, спортын мастер “Аймгийн гарамгай харваач” Бандийн Баярчулуун /33 оноо/

#### • ТАВДУГААР БАЙР

Цагдаагийн ерөнхий газрын “Хүч” спорт хороо, Дотоодын цэргийн штаб, Дорнод аймгийн Цагдаагийн газрын тамирчин, спортын мастер Жаргалсайханы Гантулга /33 оноо/





## НАСАНД ХҮРЭГЧДИЙН ЭМЭГТЭЙ ТӨРӨЛД:

### • ТЭРГҮҮН БАЙР

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын уугуул, Сайншанд сумын Их Хутагт буян ХХК, “Үсчин гоо сайханчдын холбоо”, Эрхэт 3 түрүү багийн харваач, аймгийн мэргэн, спортын мастер Энхсүрэнгийн Эрдэнэгэрэл /38 оноо/

### • ДЭД БАЙР

Дорнод аймгийн Булган сумын уугуул, “Өнөд цэнгэлийн манлай” холбооны харваач, “Сумын мэргэн” Эрхэмбаатарын Чулуунчимэг /36 оноо/

### • ГУТГААР БАЙР

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын уугуул, Замын-Үүд сумын харьяат, Дорноговь аймгийн Үндэсний сурын холбооны харваач, аймгийн гоц харваач, спортын мастер Оргодолын Осорзаяа /35 оноо/

### • ДӨТГӨӨР БАЙР

Булган аймгийн Булган сумын уугуул, Сайншанд сумын харьяат, “Өнөд цэнгэлийн манлай” холбооны харваач, “Монгол улсын онч харваач” Баянжаргалын Наадам /33 оноо/

### • ТАВДУГААР БАЙР

Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын харьяат, “Цэцэн хан мэргэд” холбооны харваач, “Өлзий мэргэн” үндэсний сурын холбооны тэргүүн, аймгийн гарамгай харваач, спортын мастер Өлзийбатын Лхагважав /33 оноо/

## ӨСВӨРИЙН ХАРВААНЫ ХӨВГҮҮДИЙН ТӨРӨЛД:

### • ТЭРГҮҮН БАЙР

Говьсүмбэр аймгийн ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 9г ангийн суралцагч, Чойр хайрхан ХХК-ийн харваач, “Жархай мэргэд” сурын холбооны тамирчин Цэрэндашийн Азжаргал /25 оноо/

### • ДЭД БАЙР

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ЕБ-ын 2 дугаар сургуулийн 6г ангийн суралцагч, Дорноговь аймгийн Үндэсний сурын холбооны харваач, Тод мэргэн клубийн тамирчин Баяржаргалын Түвшинтөр /20 оноо/

### • ГУТГААР БАЙР

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын харьяат, Угтуул зурхайн харваач Бум-Эрдэнийн Уудам /19 оноо/

### • ДӨТГӨӨР БАЙР

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын уугуул, Дорноговь аймгийн Үндэсний сурын холбооны харваач Жаргалсайханы Мөнгөн-Өлзий /19 оноо/

### • ТАВДУГААР БАЙР

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ЕБ-ын сургуулийн 10а ангийн суралцагч, аймгийн өсөх идэр мэргэн, Дорноговь аймгийн Үндэсний сурын холбооны харваач Болдбаатарын Төрболд /18 оноо/



## ӨСВӨРИЙН ХАРВААНЫ ОХИДЫН ТӨРӨЛД:

### • ТЭРГҮҮН БАЙР

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын уугуул, Сайншанд сумын ЕБ-ын 5 дугаар сургуулийн 76 ангийн суралцагч, “Эрхэт гурван түрүү” үндэсний сурын холбооны өсвөрийн харваач Бат-Амгалангийн Дэжидмаа /31 оноо/

### • ДЭД БАЙР

Улаанбаатар хот, Багануур Үндэсний сурын холбоо Уурхайчин клубийн тамирчин, Ерөнхий боловсролын “Гүн галуутай ” сургуулийн 11-1 ангийн суралцагч Батбилэгийн Билэгжаргал /29 оноо/

### • ГУТГААР БАЙР

Замын-Үүд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 6д ангийн суралцагч, “Тод мэргэн” клубийн харваач Билэгдэмбэрэлийн Төгсжаргал /28 оноо/

### • ДӨТГӨӨР БАЙР

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын ЕБ-ын сургуулийн 9а ангийн суралцагч, Дэлгэрэх сумын сурын холбооны харваач, Содномжамцын Номин-Эрдэнэ /27 оноо/

### • ТАВДУГААР БАЙР

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ЕБ-ын 2 дугаар сургуулийн 11в ангийн суралцагч, “Эрхэт гурван түрүү” багийн харваач Саруулбуянгийн Мөнх-Ану /25 оноо/

## ҮНДЭСНИЙ ШАГАЙН ХАРВАА

Шагайн харваанд 30 багийн нийт 240 харваач, ахмадын шагайн харвааны төрөлд 15 багийн 140 гаруй харваач, өсвөрийн харваанд 30 гаруй залуу харваач оролцлоо.

### • ШАГАЙН ХАРВАА

1. Монгол улсын Үлэмж дархан мэргэн Б.Баттулга ахлагчтай “Номт даншиг” баг
2. Аймгийн гоц мэргэн Д.Чинцогт ахлагчтай “Их говь энерги” ХХК-ийн баг
3. Монгод улсын хошой мэргэн Ц.Отгонбаяр ахлагчтай “Дэлгэрэх бүрд” баг

### • АХМАДЫН ШАГАЙН ХАРВАА

1. МУХМ Улаанхүү ахлагчтай Алтанширээ сумын баг
2. МУГМ Ганхуяг ахлагчтай Булган аймгийн Сайхан сумын баг
3. МУХХ Мятавсүрэн ахлагчтай Сайншанд сумын баг тус тус шалгарсан.

### • ӨСВӨРИЙН ШАГАЙН ХАРВАА

1. Төв аймгийн харваач Б.Маргад-Эрдэнэ
2. Сайншанд сумын харваач Э.Замилан
3. Иххэт сумын харваач Э.Амарболд



## 2024 ОНД “ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦ” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД НИЙТ 30 ӨРХИЙГ ШИНЭ ОРОН СУУЦААР ХАНГАЛАА

Дорноговь аймаг улсын хэмжээнд орон нутагт анх удаа иргэдийг хямд өртөгөөр чанартай орон сууцаар хангаж, амьдралын чанарыг сайжруулах “Түрээсийн орон сууц хөтөлбөр”-ийг 2023 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрийн хүрээнд 2023 онд “Дорноговь аймгийн зорилтот бүлгийн иргэдийг түрээслээд өмчлөх орон сууцанд хамруулах журам”-ыг анхлан баталж, “Мандах

наран 5” хороололд залуу гэр бүл, төрийн албан хаагч, ахмад настан зэрэг зорилтот 144 өрхөд хөнгөлөлттэй үнээр түрээслээд өмчлөх орон сууц олгосон. Түрээсийн орон сууц хөтөлбөрийг 2024 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж, журмын шаардлага хангасан (Залуу гэр бүл-10, Төрийн албан хаагч-10, ахмад настан-10) нийт 30 өрхөд шинэ орон сууц олголоо.





## ГОВИЙН БҮСИЙН 600 ГАРУЙ ЭМЭГТЭЙЧҮҮД ЧУУЛЛАА

“Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд орон нутагт эмэгтэйчүүдийн оролцоог бэхжүүлэх, эмэгтэйчүүдийн манлайлал болон гэр бүлд чиглэсэн соён гэгээрүүлэх сургалт, мэдээллийг хүргэх зорилгоор “Дулаахан” говийн бүсийн эмэгтэйчүүдийн чуулганыг зохион байгуулж, бүсийн хэмжээнд 600 гаруй эмэгтэйчүүд оролцлоо.

Чуулганд Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь аймгийн бүсгүйчүүдийн төлөөлөл оролцож, нийгэмд тулгамдаж буй асуудал, бүсгүйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хандлага төлөвшлийг сайжруулах чиглэлээр мэдээлэл хүргэн хэлэлцүүлгийг өрнүүллээ.



## ГОВИЙН БОЛОН ЗҮҮН БҮСИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ҮСЧИН ГОО САЙХАН, ХУМС ДИЗАЙН УРЛАЛЫН ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Ороннутгийн аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээний салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, ажиллагсдын харилцааны ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага судлуулах зорилгоор Говийн болон Зүүн бүсийн аварга шалгаруулах үсчин, гоо сайхан, хумс

урлалын мэргэжлийн тэмцээнийг зохион байгуулж 120 гаруй үсчин, гоо засалчид оролцлоо.

Говийн болон Зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд 13 төрлөөр өрсөлдөж багийн дүнгээр Дорноговь аймаг тэргүүлээ.





## ГОВИЙН БҮСИЙН “САР ШИНИЙН ХАРВАА- 2024” ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Сар шинийн баярыг угтан Дорноговь, Өмнөговь, Дундговь гурван аймгийн Засаг даргын ивээл дор XVII жарны “Хилэнт эх” хэмээх модон “Луу” жилийн шагайн харвааны тэмцээнийг шинийн 15, 16-ны өдрүүдэд Сайншанд хотноо зохион байгууллаа.

Говийн бүсийн “Сар шинийн харваа-2024” шагайн харвааны тэмцээнд 7 аймгийн 48 багийн 400 гаруй харваачид оролцсоноос Улсын цолтой 80 гаруй харваачид оролцож, өндөр чансаатай тэмцээн боллоо. Харвааг “Багийн харваа”, “Багийн цуваа харваа” төрлөөр зохион байгууллаа.

- **Багийн харваа төрөлд :**

Дорноговь /тэргүүн байр/  
Өмнөговь /дэд байр/  
Дундговь аймаг /гутгаар байр/

- **Багийн цуваа харваа төрөлд :**

МУ-ын Гарамгай мэргэн Ч.Буянжаргал ахлагчтай  
Өмнөговь аймгийн баг /тэргүүн байр/  
МУ-ын Үлэмж дархан мэргэн, спортын мастер  
Б.Баттулга ахлагчтай Дорноговь аймгийн “Номт  
даншиг хеттрик групп”-ийн баг /дэд байр/  
Өмнөговь аймгийн “Галбын зам” баг /гутгаар байр/

- **Шилдэг харваачаар:**

Монгол Улсын Үлэмж дархан мэргэн Гантулгын  
Бүддорж



## ТЭМЦЭЭНИЙ ҮЕЭР “АЙМГИЙН ГОЦ МЭРГЭН” ЦОЛНЫ БОЛЗОЛ ХАНГАСАН ХАРВААЧДЫГ ШАГНАЖ УРАМШУУЛЛАА.

- ШАГАЙН ХАРВААНЫ АЙМГИЙН ГОЦ МЭРГЭНЭЭР:
- Улаанбадрах сумын харваач Ганболдын Түвшинсайхан
- Сайншанд сумын харваач Чулуунсуурийн Нарансэлэнгэ
- Улаанбадрах сумын харваач Машмөнхийн Мөнхтулга
- Улаанбадрах сумын харваач Төрмандахын Батбаяр
- Улаанбадрах сумын харваач Мөнхбаярын Хишигбаяр
- Улаанбадрах сумын харваач Өвгөний Лутбаяр
- Улаанбадрах сумын харваач Төмөрсүхийн Буянбаатар
- Улаанбадрах сумын харваач Мөнхтуяагийн Мөнх-Эрдэнэ
- Сайхандулаан сумын харваач Чинбаатарын Төгөлдөр
- Сайншанд сумын харваач Цанамраашын Эрдэнэбаяр
- Сайншанд сумын харваач Дорждэрэмийн Баасандорж
- Сайншанд сумын харваач Ухнаагийн Мөнхдөл
- Мандах сумын харваач Галсанжавын Идэржаргал
- Мандах сумын харваач Өлзийбилэгийн Жаргалсайхан
- Мандах сумын харваач Цэндмаагийн Өнөболд
- Даланжаргалан сумын харваач Лхажавын Орхон нар шалгарч цол хүртлээ.





## ОРОН НУТАГТ АНХ УДАА ОЛОН УЛСЫН “БОЛОВСРОЛЫН ҮЗЭСГЭЛЭН” ЗОХИОН БАЙГУУЛЖ, ГАДААД ХАРИЛЦААГ ӨРГӨЖҮҮЛЭН АЖИЛЛАЛАА

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” үйл ажиллагааны хөтөлбөр, “Нээлттэй Дорноговь” хөтөлбөрийн хүрээнд “Bridge to Dornogobi” Олон улсын боловсролын үзэсгэлэнг орон нутгийн хэмжээнд анх удаа зохион байгууллаа.

Арга хэмжээнд дэлхийн 11 улс, орны 17 их дээд, сургууль хамтран оролцож, орон нутгийн 2400 гаруй суралцагч, оюутан залуучуудад тэтгэлэгт хөтөлбөрүүдээ танилцуулан БНСУ-ын Чонжү Их Сургуульд 50-90 хувийн тэтгэлгээр орон нутгаасаа 18 оюутан суралцуулахаар боллоо.



## ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЧААЛЛЫГ БУУРУУЛЖ, ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭЭ

Иргэд орон нутагтаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдах хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор улс болон орон нутгийн төсвийн 750 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Эмгэг судлалын төв”, “Цусны төв”-ийг байгуулахын зэрэгцээ аймгийн Нэгдсэн

эмнэлгийн хавдрын тасагт моно, полихими эмчилгээ, хэвлийн диализ эмчилгээг нэвтрүүлэн, молекул биологийн лаборатори байгуулагдсанаар лавлагаа шатлалын тусламж үйлчилгээний чанарыг нэмэгдүүллээ.





## “ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР” -ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ

Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор аймгийн ИТХ-ын 2022 оны тогтоол шийдвэрээр “Дорноговь аймгийн төрийн захиргааны албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах” зорилтот хөтөлбөрийн хүрээнд “Сумдад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдад таван жил ажилласны мөнгөн урамшуулал олгох журам”-ыг баталсан.

Энэхүү журмын болзол, шаардлагыг хангасан 106 албан хаагчид 583,0 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу 122 төрийн захиргааны албан хаагчид 572 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.



## ХАНГИ ХИЛИЙН БООМТ ДАХЬ ЭМНЭЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЛЭЭ

Алслагдсан суурьшлын бүсэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ойртуулах, бүсчилсэн хөгжлийг дэмжих зорилгоор Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ханги хилийн боомт дахь эмнэлгийг 2023 онд орон нутгийн төсвийн 1,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар бүтээн байгуулсан.

Эмнэлгийн үйл ажиллагааг 2024 онд эхлүүлэн хилийн боомтын албан хаагч, бүс нутгийн малчин иргэд, хөдөлгөөнт хүн ам зэрэг 1000 гаруй иргэнд хүрэх эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүллээ.





## СПОРТЫН АМЖИЛТЫН ЧАНАРЫГ НЭМЭГДҮҮЛЛЭЭ

Дорноговь аймгаа төлөөлөн Олон улсад нэр алдраа таниулсан баг, тамирчдын амжилтыг урамшуулж, 2024 онд тив, дэлхий, улс, олон улс, бүсийн чанартай уралдаан, тэмцээнд оролцсон 54 тамирчинд 45,9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ.

Дорноговь аймгийн баг, тамирчид 2024 онд өсвөр, залуучууд, насанд хүрэгчид, мастерсын ангилалд Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс - 8 алт, Азийн аварга шалгаруулах тэмцээнээс-2 алт, Улсын аварга шалгаруулах тэмцээнээс-109 алтан медаль хүртэж, амжилтын чанараа 50 хувиар ахиулжээ.



## “DORNOGOBI OPEN-2024” ОЛОН УЛСЫН ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Аймгийн Засаг Даргын “Хөгжлийн төлөө хамтдаа 2” үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд хүүхэд багачууд төдийгүй бүх нийтийг биеийн тамир спортоор хичээллэх, бөхийн төрлийг сурталчлан таниулах, олон улсын спортын салбарын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Арабын Нэгдсэн Эмират улсын AJP Tour компанитай хамтран

“Dornogobi open-2024” бүсийн зэрэглэлтэй олон улсын нээлттэй тэмцээнийг зохион байгууллаа. 800 оноо олгох бүсийн зэрэглэлийн тэмцээнд БНХАУ, ОХУ, Казакстан, Монгол Улсын 30 орчим клубийн 600 гаруй тамирчин оролцлоо.





ᠮᠣᠩᠭᠣᠯᠤ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠪᠣᠬᠰ ᠤᠨ ᠲᠤᠮᠴᠡᠨ ᠵᠣᠬᠢᠶ᠋ᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠠᠭᠳᠤᠯᠠ

## “ДОРНОГОВЬ ЦОМ-2024” ОЛОН УЛСЫН БОКСЫН ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Дорноговь аймгийн Засаг даргын ивээл дор холимог насны боксчдын “ДОРНОГОВЬ ЦОМ-2024” Олон улсын нээлттэй тэмцээнийг 2017 оноос уламжлал болгон 4 дэх жилдээ зохион байгуулж ОХУ, БНХАУ болон аймаг, бүсийн 260 гаруй тамирчин оролцлоо.

### Тэмцээний дүнгээр:

- Тэмцээний шилдэг шүүгчээр ОУ боксын холбооны 2 одтой Шүүгч н.Үржинбаяр
- Шилдэг эрэгтэй тамирчнаар Дорноговь аймгийн БТСГ-ын тамирчин Б.Сүхбат,
- Шилдэг эмэгтэй тамирчнаар “Ихэр бээлий клуб” -ийн тамирчин А.Алтанзул
- Өсөх ирээдүйтэй тамирчнаар Х.Амарбаясгалан, Б.Энхдүүрэн, Цасчихэр

### Багийн дүнгээр:

- Тэргүүн байр Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газар
- Дэд байр “Алдар” спорт хороо
- Гутгаар байр Өмнөговь аймгийн баг тамирчид тус тус шалгарлаа.



## “ШИНЭ ЭХЛЭЛ-2024” САГСАН БӨМБӨГИЙН ХҮҮХДИЙН ЛИГИЙН ТЭМЦЭЭНИЙГ АНХ УДАА ЗОХИОН БАЙГУУЛЛАА

“Намайг Хамгаал” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд спортоор дамжуулан хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хүмүүжил төлөвшил олгох зорилго бүхий “Шинэ эхлэл-2024” хүүхдийн лигийн тэмцээнийг анх удаа зохион байгуулж Сайншанд сумын төвийн 5 сургууль, спортын дугуйлан, клубийн 600 гаруй тамирчин оролцлоо.

Тэмцээний нийлбэр дүнгээр сагсан бөмбөг, волейболын төрөлд шилдэг оролцогчоор ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн багууд шалгарчээ.

Хоёр сарын хугацаанд үргэлжилсэн Хүүхдийн лигийн тэмцээн биеийн тамир спортоор дамжуулан суралцагчдын хөгжих, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжийг бүрдүүлсэн шинэлэг арга хэмжээ болж, 2025 онд үргэлжлүүлэн зохион байгуулахаар боллоо.





## ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГИЙН КАБИНЕТ ШИНЭЭР НЭЭГДЛЭЭ

“Дэээрэт” ОУ-ын Энэрлийн байгууллагын 136,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгтэйгээр аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн тасагт “Эрэгтэйчүүдийн кабинет”-ийг 2024 оны 2-р сард шинээр байгуулж, эрэгтэйчүүд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй орон нутагтаа авах боломжийг бүрдүүлсэн.

Тус кабинет байгуулагдсанаар 2024 онд Урологийн эмчийн үзлэгт 268 иргэн хамрагдаж, мэс заслын эмчилгээ шаардлагатай 28 үйлчлүүлэгчид яаралтай түргэн тусламж үзүүлжээ. Түүнчлэн эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр Хатанбулаг сумын Ханги хилийн боомт дээр “Эрүүл Монгол эр хүн” аймгийн зөвлөгөөнийг зохион байгуулж, эрчүүдийн эрүүл мэндийн сургалт мэдээлэл, урьдчилан сэргийлэх үзлэг, сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 851 тээврийн жолоочийг хамрууллаа.



## “ЦАХИМД ХЭВШЬЕ” ӨДӨРЛӨГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийн хүрээнд цахим шилжилтийг үндэсний хэмжээнд эрчимжүүлэх чиглэлээр “Цахимд хэвшье” өдөрлөгийг Дорноговь аймагт амжилттай зохион байгуулж, төр, хувийн хэвшлийн 500 гаруй иргэн хамрагдлаа.

Дорноговь аймгийн хэмжээнд цахим аймаг болох зорилтыг дэвшүүлэн 2022 онд бодит ажил болгон хэрэгжүүлж, Сайншанд суманд орон нутгийн төсвийн 121,0 сая төгрөгийн санхүүжилтээр “ХурДан” төвийг байгуулж, цахим шинэчлэлтийг нэвтрүүлсэн тэргүүлэх аймаг болсон. “ХурДан” төвийн үйл ажиллагааг эхлүүлснээр төрийн цахим үйлчилгээ авах иргэдийн тоо сүүлийн 2 жилийн хугацаанд 41,415 болон өргөжиж, ард иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдсэн.

Төрийн үйлчилгээний лавлах “Call center” үйлчилгээгээр дамжуулан төрийн болон төрийн өмчит 18 байгууллагын 45 үйлчилгээний талаарх мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлж, 2348 дуудлагад хариу өгч ажилласан.

Сайншанд сум дахь төрийн цахим үйлчилгээний хэлтсийн “ХурДан” төвийн үйл ажиллагааг хэвийн

явуулж, салбар цэгийг байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, тохижилт цахим шилжилтийн сургалтыг зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 61 сая төгрөгийг зарцуулсан байна.


Алслагдсан сумдад цахим үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор 2024 онд “ХурДан” төвийн салбар цэгийг 7 суманд байгуулж, иргэдэд төрийн үйлчилгээг ойртууллаа.





## ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТАД 800 ОНОО АВСАН СУРАГЧИД, БЭЛТГЭСЭН БАГШ НАРЫГ ШАГНАЖ УРАМШУУЛЛАА

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн сайд Борхүүгийн Дэлгэрсайхан, Дорноговь аймгийн Засаг дарга Очирлпүрэвийн Батжаргал, Дорноговь аймгийн ИТХ-ын дарга Батцэнгэлийн Ганзориг нар 2023-2024 оны хичээлийн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авч, сурлагын өндөр амжилт үзүүлсэн сурагч, багш нарыг хүлээн авч шагнаж, урамшууллаа.



### 800 ОНОО АВСАН СУРАГЧИД

#### • Алимаагийн Сувдаа

Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 12а ангийн суралцагч

Англи хэл болон Математикийн хичээлээр 800 оноо авч Улсад анх удаа хос 800 оноотой суралцагч болсон.

#### • Эрдэнэбаярын Будцэрэн

Сайншанд сумын 1 дүгээр сургуулийн 12а ангийн суралцагч

Математикийн хичээлээр 800 оноо авсан.

#### • 3. Энхбатын Намуун

Сайншанд сумын 1 дүгээр сургуулийн 12а ангийн суралцагч

Монгол хэл, бичгийн хичээлээр 800 оноо авсан.

#### • 4. Буяндэлгэрийн Будсүрэн

Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 12а ангийн суралцагч

Нийгмийн ухааны хичээлээр 800 оноо авсан.

- **5. Буянбатын Энхсүвд**  
Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 12а ангийн суралцагч  
Нийгмийн ухааны хичээлээр 800 оноо авсан.
- **6. Энхжаргалын Ураншагай**  
Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 12а ангийн суралцагч  
Нийгмийн ухааны хичээлээр 800 оноо авсан.
- **7. Тогтохбуянгийн Алгирмаа**  
Сайншанд сумын ЕБ-ын 5 дугаар сургуулийн 12в ангийн суралцагч  
Нийгмийн ухааны хичээлээр 800 оноо тус тус авсан.

#### БЭЛТГЭСЭН БАГШ НАР

1. Монгол Улсын гавьяат багш Базарын Бадарч Математикийн багш
2. Хундмаагийн Баярцэцэг-Сайншанд сумын ЕБ-ын 5 дугаар сургуулийн Нийгмийн ухааны багш
3. Намсрайжавын Өнөрмөнх-Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн Англи хэлний багш
4. Элбэгийн Алтантуяа -Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн Нийгмийн ухааны багш
5. Сэргэлэнгийн Энхмаа-Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн Математикийн багш
6. Гүнчингийн Баярсайхан-Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн Монгол хэл, бичгийн багш





## “ЯРГУЙ-2024” ХҮҮХДИЙН УРЛАГИЙН НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хүүхэд, өсвөр үеийнхний урлагийн авьяас чадварыг нээн хөгжүүлж, шинэ авьяастан төрүүлэх, урлагаар дамжуулан хүүхэд багачуудад гоо зүйн хүмүүжил төлөвшил олгох хүүхдийн урлагийн “Яргуй-2024” тэмцээнийг 32 дахь жилдээ зохион байгууллаа.

Тэмцээнийг Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан,

боловсролын тэргүүний ажилтан Эрдэнэжаргалын Баярсайханы нэрэмжит болгон зохион байгуулсан бөгөөд аймгийн ерөнхий боловсролын 9 болон 12 жилийн сургуулиуд, хөгжим, бүжгийн клубүүд зэрэг 970 гаруй авьяаслаг хүүхдүүд оролцож, 7 төрлөөр өрсөлдөн авьяас, ур чадвараа нэмэгдүүллээ.



## “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН ДОРНОГОВЬ АЙМАГТ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх аймгийн зорилтот хөтөлбөрийн хүрээнд айл өрх хашаандаа, аж ахуй нэгж хуваарьт талбайд мод суулгах, тарих ажлыг өрнүүлэн аймгийн хэмжээнд нийт 47.01 га талбайд 9 төрлийн 166,074 мод шинээр тарьж, ногоон байгууламжийн хэмжээг 13,8 хувиар нэмэгдүүллээ. Дорноговь аймаг үндэсний хөдөлгөөний хүрээнд 2020-2030 онд нийт 20 сая мод тарихаар зорилт дэвшүүлээд байна.





## “ЗОРИЛГЫН ХҮЧ” АРГА ХЭМЖЭЭГ 5 ДАХЬ ЖИЛДЭЭ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

“Зорилгын хүч-5” элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх сургалт, үйл ажиллагааг 2024 онд илүү өргөн цар хүрээтэйгээр зохион байгууллаа. Тодруулбал Сайншанд, Айраг, Иххэт, Замын-Үүд, Зүүнбаян багт ажиллаж байгаа багш нар болон 12 дугаар ангийн Элсэлтийн ерөнхий шалгалт өгөх суралцагчдыг бүрэн хамруулсан юм.

Тус арга хэмжээ нь аймгийн боловсролын чанарыг ахиулах, Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх үйл

ажиллагааг эрчимжүүлэх, шалгалтад амжилттай үнэлгээ авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд уламжлал болгон зохион байгуулагддаг.

Энэ удаагийн үйл ажиллагааг зорилгын хуудас бөглүүлэх, танхимын сургалт зохион байгуулах, анги хамт олны бүтээлч ажил өрнүүлэх зэргээр зохион байгуулж, шилдэг анги, багш нарыг шалгаруулан урамшууллаа.



**АНГИ ХАМТ ОЛНЫ ТӨРӨЛД:**

1-р байр С.Энхмаа багштай Сайншанд 1-р сургуулийн 12а анги

2-р байр С.Түмэнжаргал багштай Замын-Үүд 1-р сургуулийн 12в анги

3-р байр Г.Отгонжаргал багштай Сайншанд 2-р сургуулийн 12а анги

**БҮТЭЭЛЧ АНГИ УДИРДСАН БАГШААР:**

Сайншанд 1-р сургуулийн 12г ангийн Анги удирдсан багш Н.Өнөрмөнх

Сайншанд 5-р сургуулийн 12б ангийн Анги удирдсан багш Ц.Энхтуяа

Замын-Үүд 1-р сургуулийн 12а ангийн Анги удирдсан багш Ё.Мөнхсайхан

Замын-Үүд 2-р сургуулийн 12б ангийн Анги удирдсан багш Г.Энхтүвшин

**ШИЛДЭГ СУДЛАГДАХУУНЫ БАГШААР:**

Сайншанд 2-р сургуулийн математикийн багш Б.Даваа

Сайншанд 1-р сургуулийн монгол хэлний багш Г.Баярсайхан

Зүүнбаян ЕБСургуулийн англи хэлний багш Ц.Эрдэнэчимэг

**ДЭВЖЭЭ ТЭМЦЭЭНД:**

1-р байр А.Сувдаа ахлагчтай Сайншанд 1-р сургуулийн 12а анги

2-р байр О.Нямгариг ахлагчтай Замын-Үүд 1-р сургуулийн 12в анги

3-р байр Х.Мэндсайхан ахлагчтай Замын-Үүд 1-р сургуулийн 12а анги





## САЙНШАНД, ЗАМЫН-ҮҮД СУМДАД КАМЕРЫН ХЯНАЛТ, УДИРДЛАГЫН НЭГДСЭН СИСТЕМИЙН ТӨВИЙГ БАЙГУУЛЛАА

Иргэдийн амар тайван, тав тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Сайншанд, Замын-Үүд сумдад орон нутгийн төсвийн 1,6 тэрбум, орон нутгийн хөгжлийн сангийн 1,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар камерын хяналт, удирдлагын нэгдсэн системийн төвийг байгууллаа.

Түүнчлэн Мандах, Улаанбадрах, Өргөн, Хатанбулаг сумдад орон нутгийн хөгжлийн сангийн 248,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар чанарын

шаардлага хангасан хяналтын камерыг байршуулж, нийт аймгийн хэмжээнд 2,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 258 цэгт хяналтын камер байршууллаа.

Ерөнхий боловсролын 16 сургуульд гадна, дотор нийт 421 камер суурилуулж орон нутгийн төсвийн нийт 244.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүллээ.



## ЯПОН УЛСЫН ШИЗУОКА МУЖТАЙ ХАМТАРСАН “БАГШ, СУРАГЧ СОЛИЛЦООНЫ ХӨТӨЛБӨР” 12 ДАХЬ ЖИЛДЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Дорноговь аймаг Шизуока мужтай найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд 2012 оноос эхлэн “Багш, сурагч солилцооны хөтөлбөр”-ийг 12 дахь жилдээ хэрэгжүүлэн нийт 516 сурагчид хамрагдаад байна. Энэ удаагийн айлчлалаар Шизуока мужийн 20 сурагч, 5 багш Дорноговь аймагт ирж, туршлага судаллаа.

Солилцооны хөтөлбөрт хамрагдаж Дорноговь аймагт зочлон ирсэн багш, сурагчдад Монгол өв соёлоо сурталчлан таниулах зорилгоор бэсрэг

наадам, Монгол бичгээр унших, бичих багийн сургалт зэрэг 2 өдрийн турш төлөвлөлт арга хэмжээнүүдийг зохион байгуулж, хамтран ажилласан.

Түүнчлэн хөтөлбөрийн хүрээнд Дорноговь аймгийн шилдэг 17 сурагч 2024 оны 10 дугаар сард Япон улсын Шизуока муж руу очиж туршлага судалж, боловсролын байгууллагын үйл ажиллагаа, тухайн орны соёл, ёс уламжлалтай танилцаж, мэдлэг боловсролоо дээшлүүллээ.





## МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСТАЙ ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООСНЫ 75 ЖИЛИЙН ОЙ ТОХИОЛОО

Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ой тохиож, 2 улсын уран бүтээлчдийн хамтарсан тоглолт зохион байгууллаа. БНХАУ-ын Эрээн хотын “Улаан мөчир” чуулга, Дорноговь аймгийн “Саран хөхөө” театрын хамтарсан урлагийн тоглолтод нийтдээ 60 гаруй уран бүтээлчид оролцлоо.

Өнгөрсөн 75 жилийн хугацаанд хоёр улсын харилцаа шинэ түвшинд хүрч, хамтын ажиллагааны ололт амжилтаа ахиулан, өргөн цар хүрээг хамран хөгжсөөр байна.



## ӨСВӨР НАСНЫ “ХҮҮХДИЙН СЭТГЭЛ ЗҮЙ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ДЭМЖИГЧ АЙМАГ” ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛНЭ

Хүүхдийг сургууль, гэр бүл, нийгмийн орчинд аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах зорилгоор ирэх 4 жилд орон нутгийн хэмжээнд өсвөр насны хүүхдэд зориулсан сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих “Өсвөр насны хүүхдийн сэтгэл зүй, аюулгүй байдлыг дэмжигч аймаг” хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн.

Үүний хүрээнд өсвөр насны суралцагчдад сэтгэл зүйн эрүүл мэндээ тольдох анхан шатны мэдээлэл, арга зүйг

хүргэх “Сэтгэл зүйн өдөрлөг”-ийг аймгийн төвийн ерөнхий боловсролын 1, 2, 3, 5, 6 дугаар сургуулиудад өртөөчлөн зохион байгуулж, дунд болон ахлах ангийн 2000 гаруй суралцагч хамрагдлаа.

Өдөрлөгөөр дамжуулан мэргэжлийн сэтгэл зүйчдийн баг ажиллаж, өсвөр насныханд тулгамдаж буй сэтгэл зүйн өөрчлөлт, түүнийг танин мэдэх арга зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл хөдлөлийн мэдрэмжээ илэрхийлэх, ярилцах, стресс бухимдлаа эерэг аргаар зохицуулах зэрэг олон талт мэдлэг, мэдээллийг хүргэхийг зорьжээ.





## ШИНЭЭРТОМИЛОГДСОН СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРЫГ БАТЛАМЖИЛЛАА

Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаанаас сумын Засаг даргын албан тушаалд нэр дэвшигчдийг аймгийн Засаг даргад уламжилж, томилон батламжлах үйл ажиллагаа боллоо.

Хуралдааны шийдвэрээр Замын-Үүд, Сайншанд,

Эрдэнэ сумдын Засаг дарга нар улиран сонгогдож, 11 сумын Засаг дарга шинээр томилогдов.

Дорноговь аймгийн Засаг дарга О.Батжаргал “Тогтвортой бодлого-Тасралтгүй хөгжил” 2024-2028 онд аймгийг хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах гэрээг 14 сумын Засаг дарга нартай байгууллаа.



## ШИНЭЭР ТОМИЛОГДСОН СУМДЫН УДИРДЛАГУУДЫГ НЭГДСЭН СУРГАЛТАД ХАМРУУЛЛАА

Орон нутагт төрийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай шинэ мэдлэг, мэдээлэл олгох, чадавхыг бэхжүүлэх зорилгоор сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нар болон ИТХ-ын нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарыг хамруулан 2 өдрийн сургалтыг зохион байгууллаа.

Сургалтаар МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” ба “Говийн бүсийн хөгжил”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлого чиглэлтэй уялдуулан орон нутгийн түвшинд хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх арга зүй сэдвээр мэдээлэл хүргэлээ.





## СУМДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД АВТОМАШИН, ТӨВИЙН СУРГУУЛИУДАД АВТОБУС ОЛГОЛОО

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Зам тээврийн сайд Борхүүгийн Дэлгэрсайхан, аймгийн Засаг дарга Очирпүрэвийн Батжаргал нар хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хамгааллын үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор улсын төсвийн 962.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хүүхэд зорчих стандартын шаардлагад нийцсэн сургуулийн 5 автобусыг шийдвэрлэн, Сайншанд сумын төвийн ерөнхий боловсролын сургуулиудад гардууллаа.

Түүнчлэн иргэдэд хүрэх эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, техник хэрэгслээр хангах зорилгоор Айраг, Алтанширээ, Мандах, Улаанбадрах, Хөвсгөл, Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвүүдэд түргэн тусламжийн авто машин гардуулсан байна.



## 2024 ОНЫ ШИЛДЭГ СУМ, АГЕНТЛАГ, БАЙГУУЛЛАГУУДАА ШАЛГАРУУЛЛАА

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг дарга, түүний Тамгын газар, төрийн үйлчилгээний байгууллагуудын ажлын гүйцэтгэл, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, жил бүр дүгнэн ажилладаг уламжлалтай.

Энэхүү дүнд үндэслэн “Түншлэл хөгжил 2024” аймгийн зорилтот жилийн үйл ажиллагааг дэмжин идэвх зүтгэлтэй хамтран ажиллаж, хуулиар хүлээсэн чиг үүрэг, аймгийн Засаг даргатай байгуулсан төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний үүргээ хангалттай түвшинд биелүүлэн, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Засгийн газраас дэвшүүлсэн “Шинэ сэргэлт”-ийн бодлого, аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” үйл ажиллагааны хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулан 2024 оны гүйцэтгэл, үр дүнгээрээ бусдыгаа манлайлсан ШИЛДЭГ СУМ, АГЕНТЛАГ, БАЙГУУЛЛАГА-д баяр хүргэж, шагнаан урамшууллаа.

**ШИЛДЭГ СУМД:** Замын-Үүд сум, Сайншанд сум, Эрдэнэ сум

**ШИЛДЭГ АГЕНТЛАГУУД:** Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Статистикийн хэлтэс

**ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА:** Дорноговь аймгийн Музей сургалт, судалгааны төв тус тус шалгарлаа.





## “ИХ ГОВИЙН ТЭМЭЭ-2025” УЛСЫН ЗӨВЛӨГӨӨН, ТЭМЭЭЧДИЙН БАЯРЫГ 6 ДАХЬ ЖИЛДЭЭ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Дорноговь аймаг 2025 оны зорилтот жилээ “Аялал жуулчлалыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан “Их говийн тэмээ-2025” улсын зөвлөгөөн, тэмээчдийн баярыг зургаа дахь жилдээ Дорноговь аймгийн Сайншанд хотноо 02 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Уламжлал болгон зохион байгуулагдаж хэвшсэн уг арга хэмжээ нь тэмээчдийн ахуй, соёл, спортоор дамжуулан аялал жуулчлал, Монгол өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, малчин түмний хөдөлмөрийн үр шимийг алдаршуулах, тухайн чиглэлээр жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, иргэд, аж ахуйн нэгжийг дэмжин хөгжүүлэх зорилготой.

“Их говийн тэмээ-2025” улсын зөвлөгөөн, тэмээчдийн баяр наадамд Өмнөговь, Дундговь, Баянхонгор, Өвөрхангай аймгийн улс, аймгийн цолтой тэмээчид, Дорноговь аймгийн 14 сумдын тэмээчид зэрэг 350 гаруй малчин, үүлдэр угсаа сайтай 1083 тэмээ Сайншанд хотноо хуран цугларснаар улс, бүсийн хэмжээнд тэмээчдийн ахуйг сурталчлан таниулах, Монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх томоохон үйл ажиллагаа боллоо.

Анхлан Дорноговь аймгийн Мандах суманд тэмээчдийн анхдугаар чуулга уулзалт, зөвлөгөөнийг 1974 оны 03 дугаар сарын 15 өдөр зохион байгуулж, сумдаас шалгаран ирсэн 50 гаруй тэмээчин, аймгийн намын хорооны дарга нар, сумдын захиргааны дарга нар, Засгийн газрын зохицуулагч нарын төлөөллүүд оролцож байжээ. Ийнхүү тэмээн сүргийг өсгөн үржүүлэх, хамгаалах бодлогыг эрт үеэс тогтмолжуулж, өдгөө тэмээчдийн баярыг тогтмолжуулан тэмдэглэсээр ирсэн уламжлалтай.







## ИРГЭДИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ ОЙЛГОЛТЫГ ДЭЭШЛҮҮЛЛЭЭ

Дорноговь аймгийн хэмжээнд хүний эрхийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, иргэдэд эрх зүйн боловсрол олгох үйл ажиллагааг идэвхтэй зохион байгуулж, орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тодорхойлон Монгол Улсын Засгийн газрын дэргэдэх Хүний эрхийн хороонд илтгэн танилцуулснаар 2022 онд улсын хэмжээнд 2 дугаарт, 2023 онд 1 дүгээрт тус тус эрэмбэлэгдлээ. Хүний эрхийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөгөөт арга хэмжээнүүдийг түлхүү зохион байгуулан иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд анхаарал хандуулан ажиллаж байна.



## УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭРИЙГ ХАМГААЛАХ НЭГЖТЭЙ БОЛЛОО

Дорноговь аймгийн Сайншанд сумын “Ундны усны эх үүсвэрийн барилга байгууламж” нь 2024 онд улсын онц чухал объектын жагсаалтад орсноор Монгол улсын Засгийн газрын 2024 оны 35 дугаар тогтоолоор Дотоодын цэргийн 834 дүгээр тусгай салбар байгуулагдаж, Сайншанд сумын Ундны усны эх үүсвэрийн объектын барилга байгууламжийн хамгаалалтыг хэвийн, тасралтгүй зохион байгуулан ажиллаж байна. Ингэснээр хүн амын ундны усны эх үүсвэрийг хамгаалах, элдэв бохирдол, санаатай болон санамсаргүй эрсдэлээс урьдчилан сэргийлж эрүүл усны хэрэглээг бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлж буй юм.






## “ХАЙР ХЯЗГААРГҮЙ ЯЛГААГҮЙ” НӨЛӨӨЛЛИЙН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хүүхдийн эрхийг хамгаалах, нийгмийн аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хайр хязгааргүй, ялгаагүй” нөлөөллийн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд 14 сумдад холбогдох байгууллагуудтай хамтран эцэг эх, асран хамгаалагчдын дунд эрх зүйн боловсролыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, төрийн байгууллагуудын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, сургуулийн ойр орчимд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн хүнсний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр хяналт, шалгалт явуулах зэрэг төлөвлөлт арга хэмжээнүүдийг өрнүүлсэн. Нөлөөллийн арга хэмжээний хүрээнд 13000 гаруй иргэнд танхимын сургалтаар дамжуулан хууль эрх зүйн зөвлөмж, 2000 гаруй хүүхдэд сэтгэл зүйн эрүүл мэнд, хууль эрх зүй, гэр бүлийн харилцаа зэрэг олон талт мэдээ, мэдээллийг хүргэн ажиллалаа.





МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ "АЛСЫН ХАРАА-2050", ЗАСГИЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ЭДИЙН ЗАСГИЙН ТОМООХОН ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, "ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО"-ИЙН ХҮРЭЭНД ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТУУДАЙ УЯЛДУУЛАН ДОРНОГОВЬ АЙМГИЙН "АЖ ҮЙЛДВЭР, ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ"-Г БАТАЛСАН БӨГӨӨД ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, СУУРЬ ДЭД БҮТЦИЙГ БИЙ БОЛГОЖ НЭГДСЭН СИСТЕМД ОРУУЛАХ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХАРИЛЦААНД ТУЛГУУРЛАН АЖ ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГЫГ ШИНЭ ШАТАНД ГАРГАХ, ЭДИЙН ЗАСГИЙН БУСАД САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХЭД АЙМГИЙГ 3 БҮС, 5 ТОЙРОГ БОЛГОН БУСЧЛЭН ЗОХИОН БАЙГУУЛНА.

# ЭДИЙН ЗАСГИЙН 3 БҮС 5 ТОЙРОГ

## ХОЙД БҮС

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ:  
**ХҮНС, ХАА**

ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙРОГ



САЙНШАНД  
 САЙХАНДУЛААН  
 ЗҮҮНБАЯН /БАГ/



ДАЛАНЖАРГАЛАН  
 АЙРАГ  
 ИХХЭТ

## ЗҮҮН БҮС

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ:  
**ЭРДЭС, БАЯЛАГ, ХАА**

ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙРОГ



АЛТАНШИРЭЭ  
 ДЭЛГЭРЭХ  
 ӨРГӨН



ЗАМЫН-ҮҮД  
 УЛААНБАДРАХ  
 ЭРДЭНЭ

## ӨМНӨД БҮС

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ:  
**ЭРДЭС, БАЯЛАГ, ХАА**

ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙРОГ



ХАТАНБУЛАГ  
 МАНДАХ  
 ХӨВСГӨЛ



Дорноговь аймагт хэрэгжиж буй Газрын тос боловсруулах үйлдвэр, Алтанширээт үйлдвэр технологийн парк, Зүүнбаян-Тавантолгой, Зүүнбаян-Ханги чиглэлийн шинэ төмөр зам зэрэг аж үйлдвэрийн томоохон бүтээн байгуулалт өрнөж буй бөгөөд үүнийг дагасан бизнес хөгжих боломж бүрдээд байна. Иймээс аж үйлдвэрийн үйл ажиллагаа, аялал жуулчлал, үйлдвэрлэлийн гинжин хэлхээ, эдийн засгийн шинэ бүтцийг бий болгох зорилгоор Дорноговь аймгийн "Аж үйлдвэр, хөгжлийн стратеги төлөвлөгөө"-г боловсруулж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан.



## БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- “Алтанширээт” үйлдвэрлэл технологийн паркийг дагалдах бусад үйлдвэр байгуулахад бодлогоор дэмжлэг үзүүлнэ.
- “Гэрэлт говь” үйлдвэрлэл, технологийн паркийг дагалдах бусад үйлдвэр байгуулахад бодлогоор дэмжлэг үзүүлнэ.
- Хангийн боомт болон Төмөр замын дагуух орон нутгийн тусгай хэрэгцээний нутаг “Номгон”-д /Мандах суманд/ эдийн засаг, нийгмийн дэд бүтэц бүхий суурьшлын бүс шинээр байгуулна.
- “Цэвэр дулаан хангамжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эрчим хүчний шилжилтийг дэмжих” төслийн хүрээнд Сайншанд хотод 8-10МВтын нарны дулааны эх үүсвэрийг барьж байгуулна.
- “Сайншанд-Цагаан суварга” чиглэлд цахилгаан дамжуулах агаарын шугам барих төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Аймгийн төвийн дулааны станцын зуух, зарим сумдын халаалтын зууханд өргөтгөл шинэчлэлт хийж, бага чадлын бүрэн автомат ажиллагаанд шилжүүлнэ.  
“Налайх хот-Замын-Үүд” хот чиглэлийн авто замын бүсэд ногдох хэсгийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ.
- Замын-Үүд, Ханги хилийн боомтуудад чингэлэгт тээвэр, ачилт буулгалт, шилжүүлэн ачих терминалыг байгуулна.
- Замын-Үүд суманд авто тээврийн зорчигч үйлчилгээний нэгдсэн төвийн барилга барина.
- “Зүүнбаян-Баруун-Урт” хот чиглэлийн төмөр замыг барихад дэмжлэг үзүүлнэ.
- Хөдөө аж ахуйн үйлдвэр технологийн парк байгуулна.
- Түрээсийн орон сууц төслийг хэрэгжүүлнэ.
- 10000 айл хөтөлбөрийн хүрээнд “Мандах наран хороолол” болон амины орон сууцны төслийг хэрэгжүүлнэ.
- “Сайншанд-Garden city”(ногоон хот) хөтөлбөрийг хэрэгжүүлж, цэцэрлэгжүүлж, эко хот болгоно.
- Сайншанд, Замын-Үүд хот болон зарим суманд хувийн хэвшилтэй хамтран шинэ суурьшлын бүсэд “ECO”, “HYBRID”, “HOUSE TOWN” амины орон сууцны хорооллыг шинээр байгуулна.

- Замын-Үүд хилийн боомт дээр үйл ажиллагаа явуулж буй Авто тээврийн Үндэсний төв, Хилийн шалган нэвтрүүлэх цэг, гааль, хорио цээрийн бүртгэл, дардасжуулах ажиллагааг цахимжуулна.
- Орон нутгийн эдийн засгийн өсөлтөөс бий болсон үр шимийг иргэдэд хүртээх “Орон нутгийн өгөөж” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

## ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- “Говийн Дорнын Айл” Монгол гэрийн онолд суурилсан хувь хүний хөгжлийн төслийг хэрэгжүүлнэ.
- Мэргэжлийн сэтгэл зүйчдийг бэлтгэж, гэр бүл, хүүхдийн сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжиж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Хүүхэд харах үйлчилгээний төв байгуулах хувийн хэвшлийн санаачилгыг дэмжиж, гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэх боломж нөхцөлийг бүрдүүлнэ.
- “Аав, эрчүүд”, “Чанартай амьдрал-аавуудын оролцоо” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийг үргэлжлүүлэн “Child future” хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- “Өсвөр үеийнхний сэтгэл зүйн эрүүл мэнд, аюулгүй байдлыг дэмжигч аймаг” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Мэргэжлийн нийгмийн ажилтнуудыг бэлтгэж, сум бүрийг хүүхэд хамгааллын ажилтантай болгоно.
- Хүүхэд асрах газрыг байгуулна.
- Хичээлээс гадуурх үйл ажиллагаа буюу хүүхэд хөгжүүлэх секц, дугуйлан, сургалтын төвын үйл ажиллагаа эрхлэх багш нарт санхүү, байр, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ.





- Жендэрийн мэргэжилтэн, сургагч багш, шинжээчийг үе шаттай бэлтгэнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш, хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг албан байгууллага, бүх төрлийн орон сууц, худалдаа, үйлчилгээний байгууллагад мөрдүүлж, саадгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Соён гэгээрүүлэх олон талт үйл ажиллагаагаар дамжуулан хувь хүний хөгжил, гэр бүлийн боловсролыг нэмэгдүүлнэ.
- Залуу ажилтан, албан хаагчдыг дэмжих тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- «Бүтээмжийн хувьсгал»-ыг өрнүүлж, “Чадварлаг ажилтан-Тогтвортой ажлын байр” хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.
- Сайншанд, Замын-Үүд хотод төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөл бөмбөгийн стандартын талбай байгуулна.
- Ирээдүйн инженерүүд буюу 2И төслийг хэрэгжүүлнэ.
- “Англи хэлтэй Дорноговь” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- “Сүү” төслийг боловсролын сургалтын байгууллагад хэрэгжүүлнэ.



540 хүүхдийн сургууль



150 хүүхдийн цэцэрлэг



Политехникийн коллеж

- “Үдийн хоол” төслийг дунд ангид хэрэгжүүлж, хүүхдийн хоолны шим тэжээлийг нэмэгдүүлнэ.
- Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт олон улсын Кембрижийн агуулгыг нэвтрүүлж эхэлнэ.
- Төр, хувийн хэвшлийн түншлэлээр олон улсын хэлний сургалтын төв байгуулна.
- Орон нутагт “Гүүр” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хөгжлийн тэргүүлэх чиглэлээр суралцагчдад гадаад, дотоодын сургалтын тэтгэлэг олгох, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Мэргэжлийн болон техникийн боловсрол, их дээд боловсролын байгууллагын багшлах хүний нөөцийг чадавхжуулна.
- Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэнэ.
- Орчин үеийн сургалтын шаардлага хангасан “Боловсролын хөгжлийн төв”-ийн барилгыг барина.
- Салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн бааз бүхий Политехник коллежийн шинэ цогцолборын барилгыг олон улсын стандартад нийцүүлэн барина.
- АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн цогцолборын барилгыг ашиглалтад оруулна.
- «Эрүүл шүд», «Хорт хавдраас сэргийлэх, хянах», зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх, «Эрүүл Монгол» хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.
- Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар хүртээмжийг сайжруулан, эх, хүүхдийн эндэгдлийг бууруулна.
- Эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай эмнэлгийн барилгыг шинээр барьж, зарим барилгын их засварын ажлыг хийнэ.





- “Цахим эрүүл мэнд” хөтөлбөрийг хэрэгжүүлж, сүлжээний өргөтгөл, техник хэрэгслийн шинэчлэл хийж, эрүүл мэндийн үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО
- Төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож “Шилэн тендер шалгаруулалт”-ын бодлого хэрэгжүүлнэ.
- Орон нутгийн өмч хөрөнгийн бүртгэлийг цахимжуулна.
- “Түншлэл ба Хөгжил” аймгийн бизнес эрхлэгчдийг дэмжих зорилтот хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- “Дорноговьд үйлдвэрлэв” бизнес эрхлэгчдийн төвийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- Дижитал технологи, хиймэл оюун ухаанд суурилсан автоматжуулалтыг үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт нэвтрүүлнэ.
- Орон нутгийн онцлогт тохирсон үржлийн цөм сүрэг бий болгох ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, хүртээмжтэй зохион байгуулж, үржлийн аж ахуйг байгуулан өндөр ашиг шимт малын тоо толгойг нэмэгдүүлнэ.
- “Мал эмнэлгийн үйлчилгээний жишиг төв”-ийг зарим сумдад байгуулна.
- Ингэний сүүний эрчимжсэн аж ахуйг түшиглэн “Ингэний сүүний үйлдвэр” байгуулна.
- Малын гаралтай түүхий эдийг эцэслэн боловсруулах бага, дунд үйлдвэрийг дэмжин “Дайвар бүтээгдэхүүн боловсруулах” цех байгуулна.
- “Шинэ хоршоо-Чинээлэг малчин» хөдөлгөөнийг хэрэгжүүлнэ.
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, өртгийн сүлжээнд оролцох чиглэлээр малчид, тариаланчдыг сурган тэргүүн туршлагаудыг судлуулна.



23 айлын орон сууцны барилга



- “Тэжээлийн цех”, “Бордоо”-ны үйлдвэр байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.
- Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх “Залуу малчин”, “Залуу тариаланч” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Аялал, жуулчлалын агентлаг, аяллын операторын чиглэлээр нэн шаардлагатай хүний нөөц, мэргэжилтэн бэлтгэнэ.
- Орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулж, орон нутагт орох орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- Сайншанд хотын “Хамарын хийд, Ханбаянзүрх хайрхан уул”, Эрдэнэ сумын “Бүрдэнэ булаг” байгалийн нөөц газар, Даланжаргалан сумын “Их нартын хад” байгалийн нөөц газарт аялал жуулчлалын отоглох цэг байгуулна.
- «Соёлын бүтээлч үйлдвэрлэл III» хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

- Соёлын бүтээгдэхүүн, дижитал контент бүтээгчдийг дэмжиж, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- Аймгийн орон нутгийн музейн барилга барина.
- Аймгийн номын сангийн шинэ барилга барина.
- Замын-Үүд хотод орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан кино театр барина.
- Уул уурхайн нөхөн сэргээлтийг стандартад нийцүүлнэ.
- Хүн амыг баталгаат ундны усаар хангаж, усан хангамжийн эх үүсвэрт цэнгэгжүүлэх тоног төхөөрөмж суурилуулна.



Сайншанд суманд усны чанарын иж бүрэн шинжилгээний лаборатори байгуулна.

- Сайншанд, Замын-Үүд хотын хог хаягдлын ландфилл технологийг нэвтрүүлж, бүрэн шаталттай зуух суурилуулна.
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хариуцсан мэргэжлийн байгууллага /ойн анги/ байгуулна.
- ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО
- Иргэдийн онцлог байдалд тулгуурлан мэдээлэл түгээх төрөл бүрийн арга хэлбэрийг ашиглан олон нийтийг цогц мэдээллээр хангана.
- Төрийн үйл ажиллагаа, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоо, хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулна.
- Иргэний нийгмийн байгууллагын санаачилга, оролцоо, хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжинэ.
- Аюулгүй орчныг бий болгох камерын нэгдсэн системийг үе шаттайгаар шийдвэрлэж, ногоон бүсийг бий болгоно.



- “Тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад анх удаа орон сууц худалдан авах, барихад нь зориулж дэмжлэг үзүүлэх журам”-ыг хэрэгжүүлнэ.
- “Иргэн төвтэй” төрийн үйлчилгээг хэрэгжүүлж, нэг цэгээс цогц үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлж, аймгийн “Төрийн үйлчилгээний нэгдсэн цогцолбор”-ын барилгыг аймгийн төвд барина.
- Төрийн цахим үйлчилгээний “ХУРДАН”, 24/7цагаар ажиллах “СМАРТ” цэгийн тоог нэмэгдүүлж, киоск, хөдөлгөөнт цэг, төхөөрөмжүүдийг үе шаттай нэмэгдүүлнэ.
- Хилийн цэргийн анги, салбарын үйл ажиллагаа, хилчдийн ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.
- Япон, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс орнуудтай “Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- “Нэг цонх-Нэгдмэл гадаад бодлого”-ыг үргэлжлүүлж, ОХУ, БНХАУ-тай тогтоосон түншлэлийг эдийн засаг, нийгэм, соёлын хүрээнд өргөжүүлнэ.
- Стандарттай гамшгийн удирдлагыг хэрэгжүүлнэ.
- Аймгийн Онцгой байдлын газрын Депогийн барилга барина.
- Хатанбулаг сумын Ханги хилийн боомт орчмын бүс нутагт Гал түймэр унтраах, аврах анги байгуулна.



Музей сургалт, судалгааны төв



## УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨР 2024 ОНД СУМДАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА





## АЙРАГ СУМАНД ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

ДУЛААНЫ СТАНЦЫН 3-Р ЗУУХ ШИНЭЧЛЭЛИЙН АЖИЛ



ЕБС-ИЙН 1-Р БАЙРНЫ ИХ ЗАСВАРЫН АЖИЛ



ЗДТГ-Т АВТОМАШИН ХУДАЛДАН АВАХ АЖИЛ



ЭМТ-ИЙН 1-Р БАЙРНЫ ЗАСВАР ХИЙХ АЖИЛ







## ДАЛАНЖАРГАЛАН СУМАНД ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

СУМЫН ЗДТГ-Т АВТОМАШИН ХУДАЛДАН АВАХ АЖИЛ



СУМЫН СОЁЛЫН ТӨВД ЛЕД ДЭЛГЭЦ ХУДАЛДАН АВАХ АЖИЛ



ИХ НАРТЫН БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗРЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ЗАХИРГААНЫ  
ГАДНА ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН УГСРАЛТЫН АЖИЛ



ЗЭВСЭГТ ХУЧНИЙ 065 ДУГААР АНГИЙН 281 ДҮГЭЭР ТУСГАЙ  
САЛБАРЫН ШТАБЫН БАЙРНЫ ЦОНХ СОЛИХ АЖИЛ





## ДЭЛГЭРЭХ СУМАНД ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

СОЁЛЫН ТӨВИЙН БАРИЛГА /үргэлжилж байгаа/



ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН 6 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ БАРИЛГА  
БАРИХ АЖИЛ /үргэлжилж байгаа/





## ИХХЭТ СУМАНД ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

СОЁЛЫН ТӨВИЙН ДОТОР ХАЛААЛТ ГЭРЭЛТҮҮЛЭГ, ЦЭВЭР, БОХИР УСНЫ ШУГАМ СУЛЖЭЭНИЙ ЗАСВАР ХИЙХ АЖИЛ

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДАД 2-3 ӨРӨӨ ОРОН СУУЦ ХУДАЛДАН АВАХ АЖИЛ



ЦАГДААГИЙН КАБОНЫ БАРИЛГЫН ИХ ЗАСВАРЫН АЖИЛ



СОЁЛЫН ТӨВИЙН БУЖГИЙН ЗААЛНЫ ЗАСВАР ХИЙХ АЖИЛ





## МАНДАХ СУМАНД ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

ЗДТГ-Т АВТОМАШИН  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛ



ТӨВЛӨРСӨН ДУЛААН, ЦЭВЭР, БОХИР УСНЫ ШУГАМ  
СҮЛЖЭЭ БАЙГУУЛАХ АЖИЛ



СОЁЛЫН ТӨВД ТАЙЗНЫ ГЭРЭЛТҮҮЛЭГ,  
САНДАЛ ХУДАЛДАН АВАХ АЖИЛ





## МАНДАХ СУМАНД ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ГАДНА ФАСАДНЫ ЗАСВАРЫН АЖИЛ






## ӨРГӨН СУМАНД ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

ӨРГӨН СУМЫН УУРЫН ЗУУХНЫ ШИНЭЧЛЭЛ  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАН АВАХ АЖИЛ



ӨРГӨН СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ХӨГЖИМ ХЭРЭГСЭЛ  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛ





## САЙХАНДУЛААН СУМАНД ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ


ЦОХИО БАГИЙН ТӨВИЙН ЗАСВАРЫН АЖИЛ



СОЁЛЫН ТӨВИЙН ЗАСВАРЫН АЖИЛ



КАМЕРЖУУЛАЛТЫН АЖИЛ /ЕБС, ДОТУУР БАЙР, ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ГАДНА, ДОТОР, НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ ТАЛБАЙ/



ЕБС-ИЙН ХАЛААЛТЫН ЗУУХ, ТОГОО ШИНЭЧЛЭХ АЖИЛ



## ЗАМЫН-ҮҮД СУМАНД ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

СОЁЛ, УРЛАГИЙН ОРДОН, 500  
СУУДАЛ /дуусаагүй/



640 ХҮҮХДИЙН СУРГУУЛИЙН БАРИЛГА ШИНЭЭР  
БАРИХ АЖИЛ /дуусаагүй/



СУМЫН ТӨВИЙН АВТО ЗАМЫН  
ШИНЭЧЛЭЛЭЛ, 2.15 КМ



УНДНЫ УСНЫ 3000 М3 БАГТААМЖТАЙ УСАН САН



1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙГ БУУЛГАЖ ШИНЭЭР 960  
ХҮҮХДИЙН СУРГУУЛЬ БАРИХ АЖИЛ /дуусаагүй/





## ЗАМЫН-ҮҮД СУМАНД ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦ ХӨТӨЛБӨР  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ



72 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ ГАДНА ФАСАД ЗАСВАРЛАХ  
АЖИЛ



48 АЙЛЫН ОРОН СУУЦ /130, 131, 134/ ГАДНА  
ФАСАДНЫ АЖИЛ



НИЙТИЙН ОРОН СУУЦ 136 ДУГААР БАЙРНЫ ГАДНА  
ФАСАД ЗАСВАРЛАХ АЖИЛ



64 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ ГАДНА ФАСАД  
ЗАСВАРЛАХ АЖИЛ



НИЙТИЙН ОРОН СУУЦ 133 ДУГААР БАЙРНЫ ГАДНА  
ФАСАД ЗАСВАРЛАХ АЖИЛ





## ЗАМЫН-ҮҮД СУМАНД ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

НИЙТИЙН ОРОН СУУЦ 135 А,Б БАЙРНЫ  
ГАДНА ФАСАД ЗАСВАРЛАХ АЖИЛ



ТӨМӨР ЗАМЫН ГАРАМААС  
ШУНХЛАЙ ШТС ХҮРТЭЛ 2.8КМ  
ГЭРЭЛТҮҮЛЭГ ШИНЭЭР ХИЙХ



ЗАМЫН-ҮҮД СУМЫН  
ШШГХ-ИЙН ӨРГӨТГӨЛ  
БАРИХ АЖИЛ



## ЗАМЫН-ҮҮД СУМАНД ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

2-Р СУРГУУЛИЙН ХИЧЭЭЛИЙН БАЙРНЫ ГАДНА ФАСАДНЫ ЗАСВАРЫН АЖИЛ



4-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ДОТОР ЗАСВАР, ЦЭВЭР БОХИР УСНЫ ШУГАМЫН ЗАСВАРЫН АЖИЛ



НЭГДСЭН ЭМНЭЛЭГТ ТОНОГ ТӨХӨВРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ АЖИЛ



ХИЛИЙН ЦЭРГИЙН 0108 ДУГААР АНГИЙН ОРЧИН НӨХЦЛИЙГ САЙЖРУУЛАХ АЖИЛ





## УЛААНБАДРАХ СУМАНД ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН 6 АЙЛЫН ОРОН  
СУУЦНЫ БАРИЛГА БАРИХ АЖИЛ



ДУЛААНЫ УУРЫН ЗУУХ БОЛОН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛ



МАЛЧДАД ЗОРИУЛСАН ГҮНИЙ ХУДАГТ ШААРДЛАГАТАЙ ТОНОГ  
ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАН АВАХ АЖИЛ





## УЛААНБАДРАХ СУМАНД ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 065 ДУГААР АНГИЙН 253 ДУГААР ТУСГАЙ  
САЛБАРЫН ШТАБЫН БАЙРНЫ ЗАСВАР ХИЙХ АЖИЛ



ЗДТГ-Т АВТОМАШИН ХУДАЛДАН АВАХ АЖИЛ

НЭГДСЭН ДУЛААН, ЦЭВЭР, БОХИР УСНЫ ШУГАМ  
СҮЛЖЭЭ НЭМЖ ТАТАХ АЖИЛ





## ХАТАНБУЛАГ СУМАНД ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

ЗДТГ-ЫН БАРИЛГЫН ДЭЭВРИЙН  
БОЛОН ГАДНА ЗАСВАРЫН АЖИЛ



СОЁЛЫН ТӨВД ЛЕД ДЭЛГЭЦ ХУДАЛДАН АВАХ АЖИЛ



ЭМТ-Д ТУУЛАХ ЧАДВАР САЙТАЙ ДУУДЛАГЫН  
АВТОМАШИН ХУДАЛДАН АВАХ АЖИЛ





## ХАТАНБУЛАГ СУМАНД ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

ХАТАНБУЛАГ СУМ ОРОН СУУЦ /8 АЙЛ/

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ӨРГӨТГӨЛИЙН АЖИЛ /ХАЛДВАРТЫН ТАСАГ/



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 065 ДУГААР АНГИЙН 090 ДҮГЭЭР ТУСГАЙ САЛБАРЫН ШТАБЫН БАЙРНЫ ДЭЭВРИЙН ЗАСВАР ХИЙХ АЖИЛ



ХИЛИЙН ЦЭРГИЙН 0168 ДУГААР АНГИЙН ОРЧИН НӨХЦЛИЙГ САЙЖРУУЛАХ АЖИЛ





## ХӨВСГӨЛ СУМАНД ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

ЕБС-ийн ӨРГӨТГӨЛ БАРИХ, ХУУЧИН СУРГУУЛИЙН  
ГАДНА ФАСАД ЗАСВАРЫН АЖИЛ



ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГЫН ДОТОР  
ЗАСВАРЫН АЖИЛ



ЕБС-ийн БАГШ АЖИЛЧДЫН БАЙРНЫ 4 АЙЛЫН ОРОН  
СУУЦНЫ БАРИЛГАД ХАЛААЛТ, ЦЭВЭР, БОХИР УСНЫ  
ШУГАМ ШИНЭЭР ХИЙХ АЖИЛ






## ЭРДЭНЭ СУМАНД ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

ХИЛИЙН ЦЭРГИЙН 0129 ДҮГЭЭР АНГИЙН ОРЧИН НӨХЦЛИЙГ САЙЖРУУЛАХ АЖИЛ




ЭМТ-ИЙН БАРИЛГЫН ГАДНА ДУЛААНЫ АЖИЛ



 + (976) 7052-1111

 [www.dornogovi.gov.mn](http://www.dornogovi.gov.mn)

 [www.facebook.com/DGZDTG](https://www.facebook.com/DGZDTG)

 Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар



Энэхүү QR кодыг уншуулж тайлан сэтгүүлийг цахим хэлбэрээр унших боломжтой.